

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-48
<hr/>	
1.Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх тухай асуудал	7-8
2.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-26
3.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухй хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	26-39
4.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	39-48

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 26-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Х.Баттулга, Ш.Бямбасүрэн, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж өмнөх Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх асуудлыг дахин хэлэлцэх горимын санал гаргав.

Р.Сэддорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16

68.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх асуудлыг дахин хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь заалтын дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн өмнөх хуралдаанаар хураагдсан саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг дэмжсэнээр тооцож, 58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Даваагийн Ганбаярыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 14
Бүгд: 17
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Б.Батмагнай, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Борлуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл, Ж.Ганбаатар, П.Батчимэг, Б.Жаргалан, Б.Мөнхсоёл, Р.Сэддорж нарын

тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Найдалаа, Ж.Золжаргал, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4
Бүгд: 19
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Ж.Алдаржавхлан нарыг дэмжсэнээр тооцож, 89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, Ж.Ганбаатар, Б.Энхбаяр, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

Р.Сэддорж: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Ж.Ганбаатар нарыг дэмжсэнээр тооцож, 78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Геологи, үйлдвэрийн бодлогын газрын дарга Ц.Төгсбаян, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга С.Ган-Очир, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын дарга З.Батбаяр, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ч.Нандин-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, “Мон Атом” ХХК-ийн Захиргааны албаны дарга Д.Сугарсүрэн, мөн компанийн мэргэжлийн шинжээч, Монголын Мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх Я.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, М.Мандхай нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

Р.Сэддорж: “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргаланг дэмжсэнээр тооцож, 73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 30 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Ганбаатар, Лувсанжамц, Мандухай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Цэнгүүн, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Хуралдааны ирц 60 хувьтай байна. 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Хэлэлцэх асуудлаас өмнө Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах байгууллагуудын эрх бүхий албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ Монгол банкны Хяналтын зөвлөлийн дарга гишүүнд нэр дэвшихээр нээлттэй ирүүлсэн хүсэлтүүдийг хэлэлцэхдээ түр завсарлага авч дахин хэлэлцэх үед Монгол банкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг нийт нэр дэвшигчтэй хамтатган явуулсан эсэх талаар тодорхойгүй байдлаар хэлэлцсэн тул Улсын Их Хурал олон нийтэд нээлттэй ил тод байх зарчмыг баримтлан Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг дахин хэлэлцэж санал хураах горимын саналыг гаргаж байна. 2 хүн ирсэн байсан. Тэгээд зөвхөн нэгэн дээр нь санал хураасан явдал гарсан. Тэгээд нөгөө хүн нь надад санал хураалт явуулаагүй гэсэн ийм зүйл гарсан учраас горимын саналаар санал хураалт.

Горимын саналаар санал хураахыг дэмжье гэсэн томьёоллоор 68.8 хувиар горимын санал дэмжигдлээ.

Батчимэг гишүүн, Батсүмбэрэл гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Горимын санал дэмжигдсэн тул Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтүүдийг хэлэлцсэн 24-ний өдрийн үдээс өмнөх зөвхөн эхний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Ингээд тэр эхний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор, 52.9 хувийн саналаар санал дэмжигдэж, санал хураалт хүчингүй боллоо.

Батчимэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлъя. Төхөөрөмж ажиллахгүй байна. Энэ техникийн ажилтнууд ирж энэ төхөөрөмжийг шалгах хэрэгтэй байна. Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцье. Гишүүд санал хураалтад анхааралтай оролцохыг хүсье.

Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшихээр ирүүлсэн хүсэлтээр санал хураалтыг явуулна аа. Хүсэлтээ ирүүлсэн Даваагийн Ганбаяр Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 1977 онд төрсөн, эрх зүйч мэргэжилтэй, 2012 оноос одоог хүртэл Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн даргаар ажиллаж байгаа.

Ингээд Даваагийн Ганбаярыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт 17.6 хувийн саналаар санал авлаа.

Дараагийн санал хураалт хүсэлтээ ирүүлсэн Нинжбатын Ууганбаатарыг Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт. 52.9 хувийн санал авлаа. 52.9 хувиар дэмжигдэж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад Нинжбатын Ууганбаатарыг нэр дэвшүүлж сонголд оруулахаар шийдвэрлэж байна аа.

Байнгын хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна аа. Сайдын микрофоныг нэе. 3 номер.

Ц.Туваан: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 7 сарын 26-ны өдрийн 28 дугаар захирамжаар 1955 оны Монгол Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуун сухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Засгийн газраас уг асуудлыг 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах замаар шийдвэрлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ талаар БНХАУ-ын талд холбогдох саналыг хүргүүлээд байна аа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг хийх үедээ баримтлах чиглэлийг Улсын Их Хурлаар хурлаас авах зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газар хоорондын хэлэлцээрийг БНХАУ-ын талтай хийж хэлэлцээрийн төслийг эцэслэн Улсын Их Хурлаар хэлэлцүүлж олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу соёрхон батлуулахаар

төлөвлөж байгаа бөгөөд яриа хэлэлцээрийн үед баримтлах чиглэлд дараах асуудлуудыг тусгуулахаар Улсын Их Хуралд танилцуулж байна аа.

Үүнд:

1.Монгол Хятадын Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс БНХАУ-ын хооронд төрийн дээд өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх,

2.Монгол, Хятадын Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх 3 асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх.

3.Монгол, Хятадын Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх.

4.Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо Эрдэнэс Тавантолгой ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох.

5.Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх өөрсдийн хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй байх.

6.Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн нарийн царигийн аливаа маргаан дахин үүсгэхгүйг бататгах.

7.Хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж зэрэг дуусгах зарчим баримтлах.

8.Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам барих түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг Хятадын талын сонгон шалгаруулсан ААН-ээр төмөр зам түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах.

9.БНХАУ-ын хил доторх Ганц мод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд Хятадын талд гарсан аливаа алдагдал хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх.

10.Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол Хятадын хилийн Шивээ хүрэн, Сэхээ, Ханги, Мандал, Бичигт, Зүүн хатавч зэрэг боомтуудыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх.

11.Сэргээгдэх эрчим хүчний экспорт эрчим хүчний нүүрс экспортлох нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг болно оо.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Б.Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн хөгжлийн сайд, Б.Артур тус яамны Бодлогын зөвлөлийн газрын дарга, Итгэлт тус яамны Төмөр замын Далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Х.Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Э.Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга, О.Цэрэндондог Эрдэнэс Тавантолгой компанийн Борлуулалт маркетинг, тээврийн газрын дарга.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө. Батчимэг гишүүнээр тасалъя. Ингээд Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: 11.2.1.г дээр Үндэсний баялгийн санд татварын бус орлогыг төвлөрүүлэхээр оруулж байна л даа. Тэгэхээр тэрэн дээр нөгөө орон нутгийн хөгжлийн санд хуваарилдаг орлогод өөрчлөлт орох уу гэдэг асуулт байгаад байгаа юм. Уучлаарай тэгвэл би буруу асуулт асуулаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Оруулж ирж байгаа тогтоолын төслийг дэмжиж байна. Энэ асуудлыг маш олон жил гацааж ирсэн ямар ч байсан бид хэд урагшлуулж энэ улс эх орныхоо эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнолыг бэхжүүлэх чиглэлд нь анхаарах ёстой энэ зайлшгүй гаргах ёстой ийм шийдвэр байгаа юм аа. Би зүгээр энэ дээрээс 2 зүйлийг л асуух гэж байгаа юм. Энэ тогтоолын төслийн нэг дэх заалтын 4 байна. Энэ дээр ийм үг байна л даа, Тавантолгой ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл үнэний аргачлалыг жишиг болгож гэж байгаа юм. Энэ одоо яг ямар зүйлийг барина гэсэн үг вэ? Энэ чинь маш олон гэрээнүүдийг байгуулж байгаа шүү дээ. Тэгээд яг алийг жишиг болгож гэдгээ тодорхой тийм болгох юм байхгүй.

Дараа нь бас тийм үл ойлголцол гарах вий. Би ер нь зүгээр ойлгож байгаа. Тэгэхдээ энэ бол нэг жоохон тодорхой болгох эсвэл нарийвчлах асуудал байж болох уу?

Хоёрдугаарт энэ Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрөл өгөөд байгаа юм. Зөвшөөрсүгэй гээд 1 дүгээр заалт маань. Гэтэл энэ тогтоолын 1-ээс 8 дахь заалт чинь зөвшөөрөл өгч байна зөвшөөрч байна, энэ хэлэлцээрт шууд хамаатай байхгүй юу, зөвшөөрч байгаа. Харин 9, 10 чинь ерөөсөө энэ хэлэлцээртэй хамаагүй. Жишээ нь одоо 9 зөв байна. 1-ээс 9 хүртэл хэлэлцээртэй хамаатай. 10 жишээ нь зарим төмөр замуудыг үе шаттайгаар

холбох ажлыг эхлүүлэх тохиролцоонд хүрэх гэж байгаа. Би яах вэ энийг зүгээр үүрэгжүүлмээр байна. Энэ яг энэ Ганц мод-Гашуун сухайтын хил холболтын цэгтэй холбоотой асуудал биш байхгүй юу. Болж өгвөл үе шаттай биш заримыг нь ч гэсэн зэрэгцүүлээд эхэлмээр байгаа юм. Тэгэхээр энийг бол уг нь Ерөнхий сайд Засгийн газарт зөвшөөрөх биш энэ хэлэлцээрийг ингэж дээд талын есөө үлдээгээд бусад жишээ нь 10, 11-ийг бол зүгээр даалгамаар ч юм уу тийм л хувилбараар уг нь оруулж ирмээр байгаа юм. Тэгээд гол бас манай Байнгын хороо анхаарна биз. Зүгээр Эдийн засгийн байнгын хороонд даалгаж тэр 3 дугаар зохицуулалт дээр уг нь оруулах ёстой юм байгаа юм.

Яах вэ зүгээр сэргээгдэх эрчим хүчний экспорт гээд 11 дүгээр зүйл дээр бас ингээд заачаад байгаа юм. Зөвхөн сэргээгдэхээр ингэж хязгаарлах хэрэг байна уу? Ер нь зүгээр эрчим хүчний экспорт гээд. Би энэ компанийн бас үйл ажиллагаатай 2 жилийн өмнө танилцаж байсан юм. Тэгэхэд маш олон патент эзэмшдэг юм байна лээ. Бүүр аж үйлдвэрийн энэ нүүрсийг боловсруулах чиглэлийн. Хүн хүч сургадаг юм билээ. Судалгааны томоохон төвүүдтэй юм билээ. Ядаж энэ дээр бас нэг хэдэн химийн инженерүүд ер нь зүгээр. Цаашдаа нүүрсийг гэдэг юм уу дагнан судалдаг хэдэн залуучуудыг бодлогоор сургах энэ асуудлыг энэ хэлэлцээрийн явцад оруулж ирж болох уу? Бид хэд ер нь том төсөл болгоны ар дээр л үндэсний ААН-үүдээ бэхжүүлж авах, тэд нартай худалдан авах ажиллагаагаар нь дэмжиж өгөх эсвэл хүн хүч сургах гэдэг нэг л зүйлүүдийг орхигдуулахгүйгээр явж баймаар юм шиг санагдаад байгаа юм.

Р.Сэддорж: Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Үнийн аргачлал энэ асуудал маш олон жил гацсан. Та сая хэллээ. Тэгээд энэ дотор асуудлуудын нэлээн гогцоо асуудал дээр энэ үнийн асуудал байгаа юм. Тэгэхээр үнийн асуудал дээр бид бүхэн энэ Эрдэнэс Тавантолгой компанийн БНХАУ-ын тухайлах юм бол төрийн өмчит болон бусад компаниудтай нийтдээ 4 компанид одоо урт хугацааны гэрээгээр нүүрс борлуулж байгаа. Тэгээд энэ борлуулах үнийн аргачлалыг энд оруулсан байгаа. Тэгэхээр энэ дээр бол нөгөө манай улсын хуулиар Уул уурхайн биржийн тухай хуульд байгаа биржийн дундаж үнэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ компанитай нэлээн олон жил энэ хэлэлцээрийг явуулсан.

Дээрээс нь нэлээн хугацаа алдсан. Тэгээд нэлээн улс төржилт маргаантай байгаа энэ асуудал байгаа юм. Тэгээд энэ дотор энэ үнийн асуудал байгаа. Нөгөө Хятадын талаас тавьж байгаа санал бол бид нар одоо 2 улсын өндөр дээд түвшинд тохиролцсон яриа хэлэлцээний хүрээнд энэ асуудлыг шийдвэрлээд төмөр замаа бид нар барьчихсан. Танай талаас тодорхой саадууд гарсан. Ийм учраас бид бүхэнд та бүхэн Хятадын төрийн өмчит болон бусад компаниудтай олгож байгаа нүүрсний үнээрээ олгооч ээ гэдэг ийм саналыг тавьж байгаа. Тэгэхээр энэ зүйлийг оруулж өгсөн байгаа гэдгийг бас танд хэлье ээ.

Энэ 10 11 дүгээр заалт дээр болохоор энэ асуудлыг 10 дугаар зүйлийг бид нар нэлээн чухалчилж ярьж байгаа. Тэр нь юу вэ гэхээр өөрөө Хятадын талаас төмөр замын хил холболтын боомтуудыг үе шаттайгаар тухайлах юм бол Ганц мод-Гашуун сухайтын боомтыг 1 дүгээрт нь холболтын асуудал орж ирсний дараагаар дараагийн боомтуудыг ярина гэдгээ тодорхой хэлчихсэн байгаа. Тэгэхээр бид бүхэн Монгол Улстай харилцах харилцаандаа ийм бодлого барьж байгаа учраас бид бүхэн энэ гэрээг хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлагдмагц дараагийн асуудлуудаа холбоё гэдэг ийм саналыг тавьж байгаа тэгээд энийгээ Их Хурлын тогтоолын төсөлдөө оруулж өгсөн гэдгийг хэлье.

11 дүгээр асуудал дээр бол энэ сэргээгдэх эрчим хүчний экспортыг бид нар ярьж байгаа. Тэгээд ер нь манай улсын хувьд эрчим хүчний дутагдалд байгаа. Тэгэхээр ер нь

өөрсдийнхөө дотоодын хэрэгцээг ямар ч байсан эхний ээлжид хангах ийм зорилттой. Дээрээс нь дэлхийн баримталж байгаа чиг баримжаа бол одоо энэ ногоон эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч рүү нэлээн явж байгаа. Тэгэхээр энэ Чайна Энержи компани өөрөө таны хэлсэнчлэн маш олон патенттай эрчим хүчний чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ийм компани байгаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулга нэг минут.

П.Сайнзориг: Яах вэ тэгээд ерөнхийдөө юмнууд дээрээ анхаарна биз дээ. Тэгээд энэ компанийн потенциал бол нэлээн том юм байна лээ. Бид хэд чинь энэ компанийн жилийн хэрэглээний нүүрсний хэрэглээний ерөөсөө тавхан хувийг ч экспортолж чаддаггүй л орон байхгүй юу. Яах вэ энэ жил 5 хувиас нэг юм гарч байх шиг байна. Ер нь ийм л хэмжээний байгаа. Тэгэхээр энэ дээр цаанаа хүн хүч сургах мэдлэг ноу хау энүүгээрээ шингээж Монголдоо авчрах чиглэлд энэ 11 дүгээр зүйлийг илүү жоохон анхаараач ээ гэдэг зүйлийг би хүсэж байгаа.

Хоёрдугаарт 10, 11 дүгээр зүйлийг Засгийн газар зөвшөөрч энэ хэлэлцээрийн яг үндсэн нөхцөл болгохгүйгээр тусдаа заалт болгомоор байна. Энэ хэлэлцээрийг хийхтэй зэрэгцүүлээд ийм ажлыг үе шаттай хий гэдэг гэдгийг даалгая. Тэгэхгүй бол энэ үндсэн хэлэлцээрээ дараа нь энэ өгч байгаа үндсэн чиглэлээ биелсэн биелээгүй гэрээ хүчин төгөлдөр болох уу гэдэг дээр хүртэл саад болж мэднэ.

Тийм учраас та хэд хууль зүйн техник талаас нь л би яриад байгаа шүү. Энэ хэлэлцээрийн бас нэг. Тэгэхээр энэ дээрээ анхаарна биз дээ гэдэг зүйлийг би хэлж байгаа юм аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Санал байна тийм үү? Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Ер нь жоохон давхардах маягтай тэгэхдээ юу яая энэ төмөр замын чиглэлээр бусад одоо хэрэгтэй чиглэлээр боловсон хүчин бэлтгэх тал дээр энэ гэрээн дээр заалт оруулмаар байгаа. Ялангуяа энэ Хятадын тал дээр бид нар нэгэнт хөрш орнуудтайгаа хамтарч ажиллаж таарна. Хамтарч ажиллах хүрээнд нарийн мэргэжлүүдийг бэлтгэх тал дээр гэрээндээ тусгаад үүнийгээ жил болгон дүгнээд тодорхой тооны тодорхой чиглэлийн боловсон хүчнийг улс орондоо бэлтгэх бодлогыг энд заавал тусгаж оруулмаар байгаа юм, нэгдүгээрт. Энэ дээр яаж ажиллах вэ гэдэг дээр бид тайлбар авъя.

Хоёр дахь юм нь Туваан сайдыг би хувь хүнийхээ хувьд их үнэлээд байгаа. Ер нь энэ төмөр замын ажил нэлээн гацчихсан удаан хэмжээ хугацаанд гацаачихсан байсныг урагш нь явуулж байна. Энэ бол сайн ажил. Туваан сайд шиг нэг хэдэн сайд Засгийн газарт байвал Засгийн газрын ажил жоохон урагшаа явах нь ээ. Зарим нэг ажил хийдэггүй санал өгүүлдэг сайд нар байх шиг байгаа юм. Тэгээд Туваан сайд ажлаа сайн хийгээрэй. Тэгээд энэ алдагдсан боломжийн асуудал яригдаад байгаа. Ямаршуу хэмжээний боломж алдчихав аа? Үүнийг мөнгөн дүнгээр хэмжээд үзвэл хэдий хэмжээний мөнгө энэ төмөр замын гацаанаас болж Монголчууд алдсан юм бэ? Үүний цаана эх орон маань хожоод байгаа юм уу, хохироод байгаа юм уу. Үүнийг нэг хариулж өгөөч ээ.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ чиглэл авах Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулж ирж байгаа. Тэгээд бас Сайнзориг гишүүн, Батсүмбэрэл гишүүн нар энэ дээр нэмэлтээр энэ боловсон хүчин сургах асуудлыг оруулаач ээ гэдэг санал байгаа. Тэгэхээр энийг шийдвэрлэх хүмүүс

нь Их Хурлын гишүүд байгаа учраас бид бүхэн энэ асуудал дээрээ заалт болгоод оруулах ийм боломжтой гэдгийг бас танд хэлье. Тэгэхээр томъёолоод энэ асуудлаа нэмж болно. Энэ Чайна Энержи компани өөрөө маш олон салбарт үйл ажиллагаа явуулдаг. Ялангуяа эрчим хүчний чиглэлээр. Өөрөөр хэлбэл нүүрсийг жилдээ нэг тэрбум орчим тонн нүүрсний хэрэглээтэй борлуулалт өөрсдөө олборлодог. Гадаадын улс орнуудаас худалдаж авдаг ийм компани байна лээ. Тэгээд энэ компани дээр бас энэ компанитай эрчим хүчнийхээ экспортын асуудлыг бас ярих нь зүйтэй гэдэг агуулгаар энэ 11 дүгээр заалтыг оруулж ирсэн. Мөн цаашлах юм бол эднийх нүүрс химийн салбарт тухайлбал нүүрснээс шингэн түлш гаргаж авах энэ асуудал дээр нэлээн хол явчихсан технологи эзэмшдэг ийм компани байгаа учраас энэтэй хамтарч ажиллана аа. Тэгэхээр боловсон хүчний асуудал дээр 2 гишүүнтэй санал нэг байна.

Мэдээж алдагдсан боломж бол 2 талдаа байгаа. Хятадын талд ч байгаа. Хятадын тал бол ерөнхийдөө энэ төсөлд бид нар 14 тэрбум юань зарцуулна гэдэг ийм тооцооллын бид нарт зарцуулсан бөгөөд ирээдүйд зарцуулна гэж ингэж ярьж байгаа. Монголын талд бол өнгөрсөн хугацаанд энэ төмөр зам ашиглалтад ороод нүүрсний экспорт явж байсан бол зөвхөн нүүрсэн дээр 18.5 тэрбум төгрөгийн буюу ойролцоогоор нэг 5 орчим тэрбум долларын алдагдлыг бид нар хүлээсэн гэж ингэж манай яамныхан тооцоо гаргасан. Ирээдүйд бас алдагдсан боломжоос гадна энэ асуудал шийдэгдэхгүй удах юм бол бид нар бас ирээдүйд алдах маш их боломжууд байгаа. Энэ асуудал шийдэгдсэнээр энэ гэрээний 10 дугаар зүйлд тусгасан бусад төмөр замын холболтууд орно. Мөн 11 дүгээр зүйл заалтад орсон Хятадын ТӨК-удтай дараагийн явуулах энэ 11 дүгээр зүйл заалтад тусгагдсан асуудлууд шийдвэрлэгдэх ийм боломжтой гэж хариулъя аа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулга.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр гэрээн дээр төмөр зам, уул уурхай, ашигт малтмал чиглэлийн нарийн мэргэжлийн химийн инженерүүдийг бэлтгэх чиглэлийн асуудлыг оруулъя. Тэгээд үүнийг та бүхэн томъёолоод оруулах нь зөв байна аа. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо энийг дүгнэлтээ оруулбал яасан юм. Байнгын хороон дарга энийг асуудлыг ярихад нь бид нар тэгээд Их Хурлын гишүүд тэр захидалтай нь танилцсан шүү дээ. Тийм ээ маш их боломжийг бид нар алдчихсан байна. 5 тэрбум долларын боломж алдсан байна. Цаашдаа ирээдүйд бас болзошгүй алдагдлууд байна. Тэгэхээр энэ ажлыг урагш нь шуурхай явуулаарай гэдгийг танай яамныханд хэлье ээ. Тэгээд амжилт хүсье.

Р.Сэддорж: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Уул нь бол Их Хурал энэ хэлэлцээр хийе гээд л чиглэл өгчихөөс биш нэг үнийн хувьд тийм байна гэдэг бол манай Эдийн засгийн байнгын хорооны гишүүд анхаарна биз. Тэр бол ер нь болохгүй л зүйл л дээ. Энэ бол Засгийн газар өөрөө мэдээд хийх ёстой ажил байхгүй юу. Дараа нь өөрсдөө хариуцлагаа хүлээх ёстой асуудал. Тийм үнэ баримтал энэ тэр гээд чиглэл өгнө гэдэг бол бас л. Мэдэхгүй би бараг 9 жил сууж байна. Энэ бол ийм юм байдаггүй л юм л даа. Би дэмжиж байгаа, угаасаа хийх ёстой ажил. Тэгээд 2, 3 зүйл асууя. Би ер нь Уул уурхайн яамнаас нэг их юм асуудаггүй юм л даа. Ажилд нь саад болоод яах вэ гээд. Тэгээд одоо асууя даа Туваан сайдаас. Энэ бид нар чинь төсвөө батлахдаа үнээ 129 доллар гээд баталчихсан. Тэгээд 83 дээр нэмэгдээд 20 сая тонн л гэж ойлгож байгаа. Зөв ойлгож байна уу? Тэгээд би дэлгэрэнгүй юм хэлмээргүй байна л даа. Тэр урт хугацааны дундаж үнэ гэдэг чинь нэлээн доошоо орчихно. нэг их олон юм би хэлэх гээд яах вэ би дэмжиж байгаа юм. Гэхдээ наадах чинь төсвийн орлого нэлээн асуудал үүснэ. 83 гэдгээ бид нар чинь ингээд л дэмий хуваарилаад дуусчихсан шүү дээ. Төсвөө баталчихсан. Энэ дотор чинь тэр 5 номерын даргаас асууя. Тэр үг зааж өгөөд байх шиг байна

та өөрөө хариул. Тэр бартер гэж байгаа юм уу? Бартер гэж байхгүй. Алив протоколд хариулаарай тэрийгээ тэгээд. Нөгөө урт хугацаанд байгуулсан гээд байгаа 4 компани чинь бартертай шүү дээ. Нэлээн хэсэг нь. Тэр нүүрсний чанар дээр ямар байр суурь барьж байгаа юм? Одоо энэ эхний авах 29 сая тонн гэлүү эхний 4 жилд 29 билүү, 27 билүү. Ямар чанар шаардаж байгаа юм? Тэгээд би нэг зүйл хүсэхэд бол угаасаа би төсвөө баталчихсан. 83 гээд. Тэгээд 83 дээр нэмэгдэх зүйлийг ярьж байгаа гэдгийг яг протоколд үлдээгээрэй. 83-аа 129-өөрөө зарна хамгийн багадаа. Тэр чинь бид нар чинь аль хэдийн хуваагаад зарцуулчихсан шүү дээ сайхан яриад. Их Хурлын гишүүд сайхан сайхан санал гаргаад. Тэнд авна энд авна гээд хоорондоо маргалдаад ажлын хэсэг 2, 3 удаа гараад. Тэрийг тэгээд харна биз дээ. Бартер байгаа юу байхгүй юу? Тэгээд асуух зүйл их байх юм. Уг нь тэгээд явчхаасай гэж бодох юм.

Р.Сэддорж: Хариулт 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Ганбаатар сайдын асуултад хариулъя аа.

Энэ асуудал өөрөө маш их хугацаа алдчихсан маш их улс төртэй. Дээрээс нь бид нар яаралтай байгуулж байж эдийн засгаа тэлэх боломжоо бий болгох ийм төсөл байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр бас нөгөө тал бол манай Монгол Улсын баримталж байгаа бодлогууд ингээд солигдоод өөрчлөгдөөд байдаг асуудал дээр үл итгэлийн ийм асуудал байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал дээр бид нар Засгийн газрын түвшинд энэ хэлэлцээрээ амжилттай болгохын тулд чиглэлээ нэгмөсөн ингээд аваад явчихъя гэдэг байдлаар энэ үнийн асуудал бас бус асуудлуудыг оруулаад ингээд 11 зүйл заалттай. Мөн энэ гишүүдийн гаргаж байгаа саналуудыг нэмж томъёолоод ингээд оруулахаар оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ бол Улсын Их Хурлын өгсөн чиглэлийн хүрээнд бид нар дараагийн асуудлуудаа ярих учраас нэлээн өргөн тавиад орж ирсэн гэдгийг танд хэлье. Үнийн хувьд бол энэ би түрүүн хэлсэн Эрдэнэс Тавантолгой компани Хятадын төрийн болон хувийн өмчит 4 компанитай урт хугацааны нүүрс борлуулах гэрээгээрээ явж байгаа. Үүн дотор Чалко, Норенко, Винсвэй гээд энэ компаниуд байгаа. Тэгэхээр Хятадын талаас бид нар илүү дутуу янз бүрийн нөхцөл биш энэ компаниудад борлуулж байгаа үнийн аргачлалыг баримтлаад манайтай гэрээгээ хийгээч ээ гэдэг хүсэлтийг тавьсан. Тэгэхээр энэ асуудал дээр бид бүхэн бас одоо хэлэх өөр гаргалгаа гаргах ийм боломж их бага байгаа гэдгийг хэлье. Улсын төсөв дээр нүүрсийг бид нар нар 83 сая тонноор 129 биш ярилцаж байгаад 105 доллароор тавьсан байгаа гэдгийг хэлье. Тэгээд энэ асуудал 83 сая тонноосоо цаашаа нэмэгдээд явах ийм асуудлын тухай ярьж байгаа. 27 сая тонн бол 25-аас 29 оны буюу 5 жилийн хугацаанд эхний 2 жилд 5, 5 сая.

Дараагийн 4, 5 дахь жилд 6, 6 сая тонн нүүрсний асуудал нийлээд 27 сая. Үүнээс цааш энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлээд төмөр зам ашиглалтад орсноос хойш жилд 20 саяас дээш тооны нүүрс борлуулах асуудлыг ярьж байгаа.

Р.Сэддорж: Хариулт 5 номер Мөнхжаргал.

Х.Мөнхжаргал: Мөнхжаргал Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тус төслийн хүрээнд бол аливаа нэгэн бартерын нүүрсээр гэрээ байгуулах бартерлах аливаа юу байхгүй. Дэд бүтцийн хувьд бол нийтдээ 979 тэрбум төгрөгийг бол Эрдэнэс Тавантолгой компани шууд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгагдсан байгаа. Нүүрсний чанарын төрлийн хувьд бол сорчлохгүй, хатуу кокс 3-ны 1 кокс, эрчим хүчний нүүрсийг тухайн уурхайгаас олборлосон тэр нүүрс болгоныг борлуулахаар хэлэлцээрт тусгагдсан байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүн тодруулна.

Ж.Ганбаатар: Тэгээд үнэхээр гэрээ сайхан болоод амжилттай болохыг хүсье. Тэгээд эхний улирал юм уу, 2 дугаар улиралд өөр юм яриад сууж байв даа. Тэгээд 105 доллароосоо буулгахгүйгээр гол нь наад нэг 4 компанийн чинь үнийг дээшлүүлсэн юм. Хуучин бол микрофонд хэлээд яах вэ дээ. Нэлээн сонин үнэтэй байсан. Энэ 5 номерын дарга сайн мэдэхгүй байх л даа. Энэнээс өмнө гэсэн үг. Нэлээн дээшлүүлсэн байгаа шүү шахаж байгаад. Тэгэхээр тэр 105 доллартоо ядаж хүргэвэл төсвийн орлого би бол 83 дээр нэмээд яваад нэг л хол сонсогдоод л байгаа юм. Тэгэхдээ тийм болчхоосой гэж үнэхээр хүсэж байна. 1, 2 дугаар улиралд өөр зүйл ярих юм бол тэгээд би бол шахаж ажиллана аа. Тоо баримтыг чинь мэдээд аваад тэгээд таны мэдэхгүй тоог хүртэл яриад шахна шүү. Өөр юм хариулав даа амжилт хүсье.

Р.Сэддорж: Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Байнгын хорооны гишүүдэд болон асуудал оруулж ирж байгаа Засгийн газрын сайд Туваан сайд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гашуунсухайт-Ганц мод энэ хил дамнасан төмөр замын асуудал өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар Эдийн засгийн байнгын хороогоор орж ирж хэлэлцээр энэ тогтоолын төсөл хэлэлцэгдэж байгааг үнэхээр сайшааж байна. Энэ Гашуун сухайт-Ганц мод энэ хил дамнасан төмөр замын асуудал анх 2003 оноос хойш яригдаж эхэлснээс хойш 2009 онд тодорч эхэлснээс хойш үе үеийн Засгийн газрын тэргүүн гүйцэтгэгч компаниудын хувийн ашиг сонирхол энэ зөрчлийн улмаас энэ том бүтээн байгуулалтын асуудал үнэхээр хоцрогдож өдий хүрсэнд бол маш их харамсдаг. Нарийн бүдүүн цариг гэж ярьсаар байгаад л хоорондоо зодолдсоор байж байгаад л өнөөг хүрчихсэн 10 их гаруй жилийн энэ өнгөрсөн хугацаа бидэнд өнөөдөр тулж ирлээ л дээ. Тэгээд энэ Гашуун сухайт-Ганц модны энэ хил дамнасан төмөр замын асуудлыг өнөөдөр хамтарсан Засгийн газар байгуулагдаж, Улсын Их Хурал шинээр бүрэлдэж, энэ хамтарсан Засгийн газрын үед 14 мега төслийн хүрээнд хамгийн 1 дүгээрт эрэмбэлэгдэж орж ирж байгаа ийм том бүтээн байгуулалтын ажил одоо урагшлах цаг нь болсон гэж үзэж өнөөдөр бол дэмжиж байгаа. Гэхдээ сая манай гишүүдийн гаргасан саналуудад энэ нүүрсний түүхий нүүрсний үнэ энэ Хятад улсын зах зээлд эрэлт нийлүүлэлт үүнтэй холбоотойгоор үнийн хэлбэлзэл маш их байдаг учраас энэ асуудал дээр энэ хэлэлцээр дээр онцгой анхаарах асуудал гэж би харж байгаа. Бас хүний нөөц, үндэсний ажилчин, ажилчид бэлтгэх энэ асуудлыг хэлэлцээрт тусгуулья гэж протоколд оруулж байгаа гишүүдийн саналыг дэмжиж байна. Үнэхээр ажиллах хүч энэ том төсөл хэрэгжсэнээр бүтээн байгуулалт төмөр замын бүтээн байгуулалт хэрэгжсэнээр Монголын ажиллах хүчний тоо нэмэгдэх ёстой, эдийн засгийн өсөлт нэмэгдэх ёстой. Энэ нь Монгол Улсын хөгжил урагшлах ёстой.

Тийм учраас энэ Туваан сайд болон энэ төслийн багийнхан энэ ажлыг одоо үнэхээр сайн хийж чадна гэдэгт итгэлтэй байгаа. Урагшлуулж чадах тийм баг орж ирлээ гэдэгт бол үнэхээр баяр хүргэе.

Р.Сэддорж: Нэг минут Батчимэг гишүүнд.

П.Батчимэг: Ер нь бол цаашдаа энэ Чайна Энержи компанийн түүхий нүүрсний эрэлт нийлүүлэлт оноос онд, жилээс жилд ер нь буурах гэдэг хандлага бүүр сая яригдаж байсан. 2060, 2070 он гэхэд бараг түүхий нүүрсийг бол ер нь хэрэглээнээсээ зах зээлээсээ хасна гэж байсан. Энэ хүртэлх энэ орон зай энэ цаг хугацааг Монгол Улс Засгийн гзаар үнэхээр энд идэвхтэй ажиллах цаг нь болсон юм аа. Нүүрсний үнийн тэр 40, 50 сая тонноор жилд нэмэгдэх энэ эрэлт хэрэгцээ энэ нийлүүлэлтийг бол маш бодитой байдлаар ахиулж

тэгээд хэлэлцээрийн үр дүн тэр тайлагнал энэ иргэдэд зөв мэдээлэл хүргэх энэ мэдээллээ жоохон өргөжүүлмээр байна гэж би хэлмээр байна. Яагаад гэвэл иргэд маань маш дутуу мэдээлэлтэй байдгаас тэд нарын хэвлэл мэдээл.

Р.Сэддорж: Хариулт Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Батчимэг гишүүнд баярлалаа. Энэ асуудлыг дэмжиж байгаад. Тэгээд энэ төсөл хэрэгжсэнээр дараа дараагийн боомтуудын төмөр замын хил холболтын асуудлууд ээлж дараагаараа шийдэгдэнэ. Ингэснээр Монгол улсын нүүрсний экспорт хамгийн багадаа 40 сая тонноор нэмэгдэнэ. Гашуун сухайт-Ганц мод боомтоор 20 сая тонноос дээш, Ханги-Мандал, Шивээ хүрээ-Сэхээ боомтуудаар 10 сая тонноос дээшээр нэмэгдэх юм гэдэг мэдээллийг өгье. Тэгээд мөн түрүүний энэ заалтын 11-д орсон Хятадын ТӨК-удтай хамтран ажиллах хамтын ажиллагаа дээр энд орсон салбаруудаар хамтын ажиллагаа нэлээн өргөжих өөрөөр хэлбэл Хятадын талтай Монгол Улс 2 хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа нэлээн олон салбар дээр нэмэгдэх ийм гацааг гаргах ийм төсөл байгаа юм гэдгийг хэлье.

Тэгээд энэ төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын компаниуд өчигдөр МАН-ын бүлэг дээр Монголын компани Монгол ажилчдын тооны асуудал яригдсан. Тэгэхээр энэ асуудлыг тусгаж оруулъя. Тэгэхдээ энэ дээр Байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдэд тодорхой санал гаргаад тэр саналыг Байнгын хороон дээр санал хурааснаар дэмжигдээд ингээд оруулах ийм дэгтэй байх гэж бодож байна. Тэгэхээр энийг бас Сайнзориг гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Батчимэг гишүүн нар хэн нэг нь томъёолоод нэмье гэдэг саналаа оруулаад ингээд оруулах байх. Бид бүхэн иргэдэд өгөх мэдээллийг аль болох өргөн байдлаар өгөх, сэтгүүлчдэд өгөх мэдээлэл, Их Хурлын гишүүддээ өгөх мэдээлэл дээр нэлээн хүчин чармайлт гаргаж ажиллаж байгаа гэдгийг энэ дашрамд хэлье ээ.

Р.Сэддорж: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энэ гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд би тэр ажиллах хүчний асуудал хүн сургах асуудал тэр Сайнзориг гишүүн мөн бусад гишүүдтэй санал нэг байна аа. Гэхдээ энийг нөгөө 2 орны Засгийн газар хоорондын гэрээнд тусгах нь хэр оновчтой юм бэ гэдэг дээр хэдүүлээ эргэж бодох хэрэгтэй. Энэ 3 хэлбэртэй явах юм, шат дараатай явах юм.

Нэгдүгээрт 2 орны хоорондын Засгийн газар хоорондын гэрээ ингээд зөвшөөрөгдвөл энэ ингээд явна. Дараад нь бас бид нар хоорондоо протоколоор албан ёсны протоколоор протоколдоо нарийн ийм детальный асуудлуудаа ярина. Жишээлбэл Монголоос ажиллах хүчин хэдийг авч сургах юм, хэдэн хүн тэнд ажиллах юм. Монголоос ямар ААН бараа үйлчилгээ нийлүүлэх юм гэдэг ийм юмнуудаа бол 2 талын албан ёсны хийх хурлын протоколдоо тусгах нь зүйтэй байх гэж бодож байна. Эсвэл 3 дахь нь нөгөө компани хоорондын гэрээндээ тусгаж өгөхгүй бол Засгийн газрын гэрээ хоорондын гэрээнд ийм жижиг асуудал тусгах нь бас ямар байдаг юм бол доо. Энийг та бүгд маань эргэж бодоорой гэдгийг санал болгож байгаа юм шүү. Баярлалаа.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэхүү тогтоолын нэр нь бол Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай гэж байгаа. Гэхдээ энэ тогтоолоор бид нар ерөөсөө сүүлийн 15, 20 жилийн туршид Монголын улс төр,

нийгэм, эдийн засгийг бас тодорхойлж ирсэн 2 том асуудлыг шийдэх гэж байгаа юм. Нэг нь бол төмөр замын бодлогын асуудал. Нөгөөдөх нь болохоор энэ Тавантолгойн орд газрын хувь заяаны асуудал. Тэгэхээр энэ ийм том асуудлыг шийдэх гэж байгаа энэ тогтоолыг бид нар бас яаралтайгаар хэлэлцүүлж оруулж ирээд тэгээд ингэж яаруу сандруу хэлэлцэж байгаад би бол дурамжхан байгаад байгаа юм. Яагаад вэ гэхээр Засгийн газрыг ойлгож байна. Ингээд цаг нарт шахагдаж байгаа энд тэндээс яаралтай ажиллах шаардлага байгаа байх. Гэхдээ Улсын Их Хурал бол энэ дээр их нэлээн ул суурьтай шийдвэр гаргах ёстой. Өмнө нь төмөр замын бодлогын тал дээр ч гэсэндээ тэр Тавантолгойн тал дээр ч гэсэндээ тэр хэд хэдэн Улсын Их Хурлын тогтоолууд гарч байсан.

Тэгэхээр энэ тогтоолыг тэр талаас нь харж үзээсэй. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд маань энэ дээр туйлын хариуцлагатай байгаасай гэдгийг эхний ээлжид хэлэхийг хүсэж байна аа. Тэгээд энэ тогтоолоор яаж байна вэ гэхээр нэг ийм 3 асуудлыг цогцоор нь шийдье гээд Хятадын талаас ирсэн нэг албан бичигт дурдагдсан нэр томъёог ашигласан байдлаар энэ тогтоолоо боловсруулсан байгаа.

Тэгэхээр ямар 3 асуудал байгаа вэ гэхлээр 1 дүгээрт төмөр замын бүтээн байгуулалт. Энэ хэл холболтын тухай асуудал. Тэгэхээр энэ дээр бол нэг тодорхой асуудал байгаа нь протоколд тэмдэглүүлээд авахыг хүсэж байна. Энэ хил холболттой холбоотой асуудлаар урьдчилсан хэлэлцээрээр манай талаас яг ямар хэдэн төгрөгийн зардал гарах вэ? Барилга угсралтыг айлын талаас сонгон шалгаруулна. Тэгээд 1 зураг төсөлтэй явна гэсэн тийм зүйл заалт 7, 8 дугаар заалтад дурдагдсан байгаа. Гэхдээ энэ барилга угсралтын үйл явцад Монголын талаас ямар түүхий эд авах юм, Монгол талаас хэдэн ажлын байр бий болох вэ гэдэг дээр яг тодорхой хариулт хэлж өгнө үү.

Хоёрдугаар асуудал нь нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ. Энэ урт хугацааны гэрээний хүрээнд 16 жил буюу эхний 4 жилд нь 27 сая, дараах 12 жилд нь 20 сая, нийт 267 сая тонн нүүрсний асуудал яригдаж байна аа. Тэгэхээр нөгөө бусад Эрдэнэс Тавантолгойн урт хугацааны гэрээнүүдтэй адилхан тэрнээс дордуулахгүй байдлаар үнээ тогтооё гэж хэлээд байгаа. Тэр саяын уул уурхайн сайдын дурдсан тэр урт хугацааны гэрээнүүд дээр ер нь яг ямар нөхцөл үйлчилж байгаа вэ? Тэр нь одоо энэ биржийн үнээс хэдэн хувийн дискаунттай буюу хөнгөлөлттэй тийм үнэ явж байгаа вэ гэдгийг яг тодорхой хэлж өгнө үү? Энэ нэмээд цагаа авчихъя тэгэх үү?

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн, Мөнхсоёл гишүүн нарыг нэмье. Жаргалан гишүүн нэг минут.

Б.Жаргалан: Тэгээд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль гэж байгаа. Үүн дээр бол нэг аливаа асуудал дээр биржийн үнийг баримтална гэсэн заалт орсон байгаа. Тэр заалтыг юу гэж харж байгаа вэ гэж асуумаар байна. Тэгээд энэ 267 сая тонны урт хугацааны гэрээн дээр манайх ер нь бол яг тэр үнийн хөнгөлөлтийн улмаас 20 жил энэ 16 жилийн туршид яг ямар хөнгөлөлт үзүүлэх вэ? 3 дугаар асуудал нь болохоор уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд нэг зүйл яваад байгаа. Үүн дээр Эрдэнэс Тавантолгой дээр шинээр ам нээх юм уу, ам өгөх юм уу? Оператор компанийг хэрхэн яаж шалгаруулах вэ? Оператор компани нь хаанах байх вэ? Энэ оператор компанийн олборлох үйл ажиллагаанд Монгол Монгол талаас хэчнээн ажлын байр бий болох вэ? Хэдэн Монгол компани энэ дээр ажиллах боломжтой вэ? Би бол хил холболт хийх ёстойг дэмжиж байгаа боомтуудаа нээхийг дэмжиж байгаа. Энэ бүхнийг явуулах ёстой гэж үзэж байгаа. Гэхдээ алдагдсан боломж гэх мэт том том юм яриад ийм айлын аманд ороод баймааргүй байна аа. Тэгээд Засгийн газрын гишүүд нь ч тэр Улсын Их Хурлын гишүүд нь ч тэр аль нэг харь улсын компанийг магтаад энэчээ яриад суугаад баймааргүй байна. Тэгээд энэ Засгийн газрын хоорондын хэлэлцээр гэж

ойлгож байгаа. Аль нэг компанитай хийж байгаа хэлэлцээр гэж бодохгүй байгаад байна. Тэгээд энэ дээр бид нар тийм хариуцлагатай. Ингээд энэ тоонуудаа мэдэж яримаар байна гэдгийг хэлэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад хариульа аа.

Энэ бүтээн байгуулалтад нийтдээ 978 тэрбум төгрөг шаардана. Энэ мөнгийг Эрдэнэс Тавантолгой компаниас бэлнээр өгнө. Энэ дээр ямар нэгэн нүүрсээр ямар нэгэн гэрээ хийж бартер маягаар хийхгүй ээ гэдгийг хэлье. Хятадын талын төмөр замын суурь бүтэц эзэмшигч компанийн шалгаруулсан компаниар хийгдэхээр гэрээнд тусгагдаж байгаа. Тэгэхээр энэ өөрөө асуудал маань БНХАУ руу Монгол Улсаас өргөн царигийн төмөр зам өөрөө орно. Тэгээд ороод тэндээ өргөн царигийн төмөр замын терминал байгуулагдана. Хятадын талаас Нарийн царигийн төмөр зам Монгол улс руу орж ирнэ. Нарийн царигийн төмөр замын терминал Монгол талд байгуулагдана. Өөрөө газар зүйн нөхцөл байдлын хувьд нэлээн тийм усны урсац тийм голын сайр дагасан ийм хүндрэлтэй нөхцөл байдал байгаа. Тэгэхээр энэ дээр маш өндөрт цементэн тулгуур багана дээр төмөр зам баригдана дээрээс нь ойролцоогоор 30 метр буюу 10 давхар байшингийн дайны өндөрт баригдах зарим хэсэг дээрээ 2 төмөр зам нэг гүүрээр зөрөх ийм байгууламж байгаа. Тэгэхээр энэ дээр нэлээн туршлага шаардсан ийм ажлууд хийгдэнэ гэдгийг хэлье.

Урт хугацааны гэрээ байгуулагдаж байгаа энэ дээр үнэ дээр бол микрофонд хэлчихье. Өмнө нь Шинхуа гэдэг компани явж байгаад одоо Чайна Энержи компани болсон. Энэ компанитай төмөр зам барих асуудлууд түрүүн Батчимэг гишүүний үгэнд гарсан. 2003 он, 2009 он гээд ярьж байгаад 2011 онд Чалко компанитай шууд гэрээг байгуулсан. Чалко компани бол тодорхой хэмжээний мөнгийг Монгол Улсад хүүтэйгээр зээлүүлээд 2028 он хүртэлх гэрээг ингээд хийгээд явж байгаа. Тэр үед бас яриа хэлцэлд орж байсан энэ Шинь Хуа буюу өнөөдрийн Чайна Энержи компани бас нэлээн асуудлыг ярьдаг аа.

Тэгэхээр үнэ дээр бид нар янз бүрийн хөнгөлөлт гэхээсээ илүү Тавантолгой ХК-аас Хятадын 4 компани тухайлах юм бол тэрэн дотор Чалко компани орж байгаа. Бодож байгаад үнийн аргачлалыг баримтлаач гэдэг зүйлийг санал тавьсан. Бид нар энэн дээр өөр одоо хэлэх үг байхгүй. Биржийн дундаж үнээ баримтална гэж хэлэх ийм боломжгүй байгаа гэдгийг энд хэлье. 16 жилийн хувьд бол мэдээж Хятадын талаас 20 жилийн хугацаатай гэрээ байгуульа гэдэг зүйл ярьсан. Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр энэ хугацаа арай урт байна гээд. Ингээд 16 жил гэдэг зүйл дээр ярьсан. Өмнө нь судалгаа хийгдсэн Тавантолгойн лицензтэй 8 лиценз байгаа. Энэ лицензтэй Бор толгой, Онч хараат гэдэг 2 талбай байгаа. Энэ талбай дээр шинээр ам нээж байж.

Р.Сэддорж: Хариулт гүйцээж хариульа 3 номер.

Ц.Туваан: Энэ нүүрсийг бид нар одоо борлуулах ийм боломж бүрдэнэ. Өнөөдрийн Эрдэнэс Тавантолгой компани жилдээ нэг 30 гаран сая тонн нүүрсийг максимум хүчин чадлаараа олборлож борлуулж байгаа. Тэгэхээр цаашдаа нэмж нүүрс экспортод гаргахын тулд бол ийм амыг нээнэ гэдгийг хэлье. Мэдээж энэ хэн оператор хийх вэ гэдэг дээр нээлттэй тендер зарлана. Энэ дээр компаниуд оролцоод сонгон шалгарсан компани операторын үйлдлийг хийнэ. Энэ дээр мэдээж туслан гүйцэтгэгчээр Монголын компани Монгол ажилчид оролцох эрхүүд нь нээлттэй байгаа гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. Асуулт уу? Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Ямар ч байсан энэ асуудлыг бид нар нэлээн хэлэлцэж байна. Өчигдөр бас манай ХҮН намын зөвлөл дээр энэ танилцуулгыг сонссон, асуух зүйлээ асуучихсан. Бусад гишүүд маань ч асууж, хариулт авч байна. Зүгээр нэг юм хэлэх гэсэн юм. Гол санаа зовж байгаа зүйл энэ гэрээнд борлуулалтын хэмжээ шүү дээ экспорт тэгээд дээрээс нь үнийн асуудал байнга яригдаад байгаа. Тэгээд нөгөө олон 2003 оноос хойш явчихсан гэрээний асуудал маш олон уулзалт тэгээд дунд нь маш олон төрлийн экспортын үнийн асуудлууд яригдаж байгаа энэ үед өчигдөр бид нар бас Оронагийн гэрээг сонссон байхгүй юу. Тэрэн дээр санхүүгийн загварчлал гээд фаст гээд Англи дээр уян хатан байдал, зохимжтой байдал, ил тод байдал энэ тэр гэсэн олон асуудлыг агуулсан ийм загварчлал ашигласан байна лээ. Тиймэрхүү ийм загварчлал ашиглаад энэ гишүүд болон иргэдэд ойлгомжтой байдлаар бүх цаг хугацаатай нь кашло мөнгөний урсгалыг харуулсан тийм үнэ мэдээллийг харуулсан ийм цогц нэг материал гаргавал их зүйтэй юм гэсэн асуулт уу, санал уу бүү мэд ингээд хэлчихье гэж бодлоо. Баярлалаа.

Тэгэхгүй бол угаасаа өөрөө асуудал нь маш нухацтай маш анхаарал татсан олон хүчин зүйлд цогц асуудал байгаад байдаг үе үе орж гараад ингээд яриад байхаар хүнд юм үлдэхгүй байна. Нэг маш сайхан иж бүрэн мэдээллийг ингээд яачихмаар байна шүү загварчлаад үнийн дүн энэ тэрээ оруулаад. Баярлалаа.

Р.Сэддорж: Санал уу? 3 номер хариулах уу? Туваан сайд.

Ц.Туваан: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Түрүүн бас Дэлгэрсайхан сайд хэлсэн. Энэ эхний БНХАУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрт чиглэл авах асуудал яригдаж байгаа. Энэний дараа энэ шийдвэр гарвал бид нар Хятадын тал Засгийн газартай хэлэлцээрт орно. Тэгээд хэлэлцээрээ байгуулсны дараагаар ААН-үүд хооронд, компани хоорондын нөгөө 3 асуудлаа шийдэх гэрээнүүд явна. Тэгээд энэ гэрээнүүд зурагдана. Тэгэхээр энэ бол эцэслэж байгаа асуудал биш. Цаашдаа энэ асуудлууд Их Хурлаар соёрхон батлах болон хэлэлцээрийн явцын асуудал ингээд яригдана. Орона дээр бол бид нар өмнө нь Цөмийн энергийн хуульд өөрчлөлт оруулснаар энэ Оронагийн гэрээ өнөөдөр Улсын Их Хурлын тогтоол байдлаар орж ирж байгаа нь өнөөдөр хэлэлцэгдэнэ. Үүнтэй хавсралтаар компанийн гэрээ байгуулж байгаа хөрөнгө оруулалтын гэрээ эцсийн байдлаараа хавсралтаар орж ирнэ. Тэгэхээр бас Их Хурал дээр энэ Гашуун сухайт-Ганц модны хил холболтын асуудлаарх хэлэлцээр мөн эцэслэн соёрхон батлах хүрээнд орж ирэх үе дээр энэ мэдээллүүдийг ялангуяа энэ таны хэлсэн эдийн засагтай холбоо холбоотой мэдээллийг оруулж танилцуулья аа.

Р.Сэддорж: Баярлалаа Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Өдрийн мэнд. Ард түмэн нэг л зүйлийг хүсээд байгаа байхгүй юу. Тэрэн дээр л тооноосоо таниулаад өгчихмөөр байна. Энэ төсөл хэрэгжвэл бид нар яг жилд хэчнээн тонн нүүрсийг илүү гаргаад манай орлого хэдээр нэмэгдэх юм бэ гэдгийг л одоо жирийн ард түмэн бол тэр л ч чухал байгаа шүү дээ. Тэрнээс өөр нарийн ширийн тэр үнэ өртөг өөр жирийн юм ард түмэнд айтгар сонин биш. Ерөөсөө энэ ашиглалтад орчих юм бол Монгол Улсын орлого маань тэгж нэмэгдэх юм гээд маш энгийн зүйлийг хэлж өгөөч ээ гэж.

Хоёрдугаарт төмөр замын суурь бүтэц эзэмшигч Хятадын компани байна гэж байгаа юм. Тэр чинь нийт төмөр замынхаа суурь бүтцийг эзэмших гээд байгаа юм уу? Зөвхөн Хятадынхаа талын суурь бүтэц эзэмших юм уу гэж. 2 дугаарт ийм асуулт байна.

Гуравдугаарт нөгөө өргөн төмөр зам чинь 30 сая тонны нүүрс гаргана гээд байгаа байхгүй юу. Тэгсэн нарийхан нь болохлоор 10 сая тонн гээд байгаа юм. Тэгээд энэ чинь яах юм? Тэгээд 20 саяыг нь хасах юм уу? Яаж холбогдох юм бэ? 30 саяар явуулдаг. Цаана нь 10 саяын хүчин чадалтай юм уу ямар учиртай юм? Энийг нэг хариулж өгөөч.

Р.Сэддорж: Хариулт Дэлгэрсайхан сайд, дараа нь Туваан сайд хариулах юм байна.

Б.Дэлгэрсайхан: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя аа. Төмөр замтай холбоотой учраас би хариулъя гэж байгаа юм. Нэгдүгээрт өргөн төмөр замаар ачилт хийхэд уурхай дээрээс шууд ачигдаад тэгээд шууд хил гарч байгаа юм. Хилийн цаана Ганц модны боомт дээр Хятадын талдаа ачиж буулгах терминал нь баригдсан вагоныг хөмрөх тийм маягаар буулгана, тэгээд тэр нь өөрөө тэндээ бас нэг 10 сая гаруй тонн нүүрс нөөцлөх тийм савтай тэрүүгээрээ дамжаад цаашид тээвэрлээд явах учраас өргөн царигаар нэг 30-аас доошгүй сая тонн нүүрс гарах юм байна гэж үзэж байгаа юм. Нарийн царигийн төмөр замаар Монгол талдаа ачилт хийнэ. Энэ бол хил дээрээс ачих юм. Яагаад вэ гэхээр бид нар нөгөө хуучин шигээ ингээд өнөөдрийн зөөж байгаа шигээ ингээд нарийн цариг ороод ирвэл машинаар тээвэрлээд тэгээд нарийн царгийнхаа терминал дээр аваачаад өөр контейнероор нь юутай нь өргөөд ингээд ачих энэ боломжийг бид нар 20 сая орчим тонн байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ төмөр зам ашиглалтад орсноороо нүүрсний өөрийн чинь хэлдгээр бол экспорт хамгийн багадаа 40-өөс 50 сая тонноор нэмэгдэнэ гэж үзэж байгаа. Дээр нь машины тээвэр үргэлжилж явагдана. Ингээд Монгол Улс зөвхөн одоо Гашуун сухайт-Ганц модоор хамгийн багадаа 120-оос 130 сая тонн нүүрс гаргах ийм боломжтой гэдэг ийм асуултад хариулъя аа.

Юуны хувьд, суурь бүтцийн хувьд бол аль аль улс өөр өөрийнхөө нутаг дэвсгэр дээр байгаа суурь бүтцүүдээ өөрс өөрсдөө л эзэмшдэг. Энэ бол тийм зүгээр төмөр замын өнөө харилцан бараа солилцож байгаа журмаараа бол цаашаа Хятадын нутаг руу гарч байгаа өргөн цариг бол суурь бүтэц нь манай эзэмшлийнх. Наашаа гарч ирж байгаа нарийн царигийн төмөр зам бол урд хөршийн эзэмшлийнх байх ёстой. Энэ олон улсын төмөр замын дүрмээрээ угаасаа л ийм байдаг. Баярлалаа.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Алдаржавхлан гишүүний асуултад нэмэлтээр хариулъя аа. Бид нар доод хэмжээнүүдээ тавьж өгч байгаа. Нүүрсний экспорт дээр нэг 20 сая тонн энэ төмөр зам энэ хил холболтын асуудал орсноор гэж байгаа юм. Ер нь бол энэ Хятадын талын Ганц мод хүртэлх барьчихсан байгаа төмөр замын хүчин чадал бол 50 сая тонны хүчин чадалтай. Монголын талаас Тавантолгой уурхайгаас хил хүртэл явж байгаа өргөн царигийн төмөр зам бол 30 сая тонноос одоо доошгүй ийм хүчин чадалтайгаар баригдсан байгаа гэдгийг хэлье. Тэгээд өшөө нэмэлтээр 120 сая тонноос доошгүй болгоно гэдэг зорилт нь бол Шивээ хүрэн, Сэхээ, Ханги Мандалын төмөр замуудын холболт орсноор 10, 10 саяас доошгүй хэмжээний нүүрс бас экспортод гарна гэж үзэж байгаа. Нөгөө 2 боомтын төмөр замууд аль аль талаасаа Хятадын талаас ч тэр, Монголын талаасаа ч тэр төмөр зам комууд нь хил дээрээ тулчихсан холболтынхоо асуудлыг хүлээж байгаа ийм асуудал байгаа. Тэгээд нүүрсний нэмэгдсэн борлуулалт хэд байхаас шалтгаалаад ингээд эдийн засгийн үр өгөөж нь нэмэгдэнэ. Ойролцоогоор 1.5-аас 2 их наяд төгрөгийн борлуулалт 20 сая тооноос дээш экспортолбол гарна. Тэгээд өшөө дээшээ нэмэгдвэл энэ хэмжээ нэмэгдээд явна гэдгийг танд хэлье.

Р.Сэддорж: Асуулт 11 дээр Хил холболтын дэд бүтцийн бүтээн байгуулалт ингээд орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллана гэж. Ажлын байр хэдий хэмжээгээр нэмэгдэх бол? Орон нутгийн хөгжлийг дэмжих гэсэн энэ заалт энэ орон сууцжуулалтын өмнө оруулж болохгүй юу? Эрдэнэс Тавантолгой компани энэ ачилт дээрээ бол сайн анхаарч байгаа биз дээ? Ачилтаа боловсронгуй болгох тал дээр анхаарч байгаа биз дээ? Одоо ингээд төмөр зам ашиглалтад ороод хэвийн горимоор ажиллах хажуугаар нь авто тээвэр явна, явдгаараа явна. Ачилт боловсронгуй болгох шаардлагатай байгаа. Ингээд энэ хос замын хос авто замын асуудал зогсонги байдалтай байгаа. Зам, тээврийн яам энэ замыг бол мэдэж байгаа байх. Энэ зам ашиглалтад ороогүйгээс ямар олон хүний эрүүл мэнд амь нас хохирч байгаа бол тэгээд энэ замыг бас анхаараач ээ.

Цаашдаа төмөр зам, авто зам хосолсон байдлаар явах нь тодорхой. Тэгээд эдгээр асуултуудад хариулт авъя.

3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ маш чухал асуудал тэгээд мэдээж энэ асуудал шийдэгдсэнээр шат дараатайгаар маш олон асуудлууд шийдэгдэж Засгийн газрын үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөрийн дагуу нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган доллароос дээш гаргах, ДНБ-ээ 2 дахинаас дээш нэмэгдүүлэх ийм зорилтууд явж байгаа. Тэгээд үүнийгээ дагаад Монгол компаниуд, Монгол ажилчид дотор ажлын байр нэмэгдэх асуудал орж ирж байгаа. Энэ 11 дээр яригдсан асуудлууд дээр Хятадын Чайна нэртэй ТӨК-уд ингээд л Чайна Энержи, Си Эн Пи Си гээд ингээд энэ компаниуд бүгдээрээ төрийн өмчит учраас холбоотой ажилладаг. Тэгээд энэ асуудал явсны дараагаар эдгээр тухайлах юм бол энэ сэргээгдэх эрчим хүч, эрчим хүч тэгээд говийг усжуулах орон сууцжуулах энэ бусад асуудлууд нь дагаад яригдахад нээлттэй гэж ингэж ярьж байгаа. Хятадын талд бол одоо дэд бүтцийн орон сууцын маш олон компаниуд байгаа.

Тэгэхээр хийх ажил байвал хийхэд бэлэн байгаа гэдгийг ярьж байгаа. Тэгэхээр бид нар энэ асуудлуудаа 11 дээр томьёолж оруулж ирсэн. Тавантолгой дээр бид нар ачилтын буюу таналт гэж ярьж байгаа тээвэр нүүрс ачилтын нэгдсэн терминалын асуудлыг шууд конвеераар дамжуулаад вагонд очих төв баригдсан. Энэ төвийн хүлээж авах ажлын хэсгийг манай яам Зам, тээврийн яам хамтраад хүлээж аваад улсын комисс хүлээж аваад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ асуудал нь бол нэлээн тийм боловсронгуй байдлаар шийдэгдэж байгаа гэдгийг бас хэлье. Хос авто зам дээр Дэлгэрсайхан сайд нэмээд хариулчихъя.

Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Сэддорж даргын асуултад хариулья аа. Энэ авто замыг хос болгох асуудал бас нэлээн уг нь бол ярвигтай асуудал байгаа. Тэгээд энийг энэ жил шийднэ ээ. Яагаад вэ гэхлээр энийг барьж байсан компани нь өөрөө зогсчихсон байгаа. Санхүүгийн байдлаас болоод дээрээс нь концессын хугацаа нь дуусчихсан. Тэгээд энэ концессын хугацааг нь дүгнээд энэ ямар зардал гарсныг нь мэргэжлийн байгууллагуудаар тооцоо гаргуулаад тэгээд дараагийн концессыг зарлаад тэгээд дараагийн орж ирсэн компани өмнөх явуулж байгаа замын концессынхоо хохирлыг төлөөд тэгээд энэ замыг үргэлжлүүлж явуулах ёстой гэдэг дээр Зам, тээврийн яам бодлого барьж байгаа гэдгийг илэрхийлье ээ. Баярлалаа.

Р.Сэддорж: Энэ бүтээн байгуулалтууд Монголын талдаа нэлээн ачих буулгах терминалууд хийгдэнэ. Харамсалтай нь ус байхгүй, гаалийн шинэ барилга сая Гашуун сухайт дээр хүлээж авсан. 40, 50 км метрээс ус машинаар зөөж хэрэглээний усаа хангаж

байгаа. Тэгээд усны асуудлаа та бүхэн маань энэ бүтээн байгуулалтынхаа энэ юун дээр яаралтай шийдэхгүй бол Тавантолгой, Оюу Толгойн усны асуудал бол хойшоо 200 гаруй, 100 гаруй километр байгаа тэр үйлдвэрүүдийн тухай шүү дээ. Энэ чинь урагшаа өмнөд хил дээр байгаа олон мянган жолооч олон мянган хүний ажлын байр тэнд байгаа. Одоо байгаа цаашдаа нэмэгдэх учраас хэрэглээний ус үнэхээр усгүй газар. Хэрэглээний усны асуудлаа давхар тооцоорой гэдгийг хэлье ээ.

Гишүүд асуулт асууж дууслаа. Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Батсүмбэрэл гишүүнээр нэрсийг тасалж байна. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Тогтоолын төслийг дэмжиж байна аа. Тэгээд уг асуудлыг ил тодоор иргэд олон нийтдээ зөв мэдээллийг өгөөд харилцан ашигтай байх талд нь илүү их анхаарах чиглэлийг удирдамжийг Улсын Их Хурлаас өгөх нь зөв байгаа. Ер нь тэгээд аж ахуйн хэлэлцээр улс төржилт гэдэг юм уу тодорхой гаднын дотнын эрх ашгуудаас болж ийм өндөр цэг дээр ирж шийдэгдэх гэж байгаа нь их инээдтэй л байгаа юм. Энэ уг нь 2 аж ахуйн нэгж байгууллага шийдээд явчих байлаа. Төмөр замтайгаа ингэтлээ бүүр холбогдох хэрэггүй байлаа. Одоо тэгээд л гарцаагүй л ийм байдал дээр орж байна л даа. Тэгээд энийг 2 аж ахуйн нэгж байгууллага хоорондоо шийдчих асуудал гээд шийдэх юм бол хэн ч зурж чадахгүй. Бүгд ажил хийж байгаа хүмүүс. Энэ дээр Улсын Их Хурал ямар нэгэн байдлаар оролцож чиглэлээ өгөөд тодорхой зарчмыг нь тогтоож өгөөд хэлэлцээр урагшаа амжилттай явна гэдэгт би итгэлтэй байгаа. Тэгээд яах вэ зүгээр тогтоолын төслийг хэлэлцээд сайжруулах явц дээр анхаарна биз дээ. Тэр 10, 11 дүгээр зүйл бол яг энэ Засгийн газарт зөвшөөрөх гэхээсээ илүүтэй даалгамаар байна аа. Зарим боомтуудыг зэрэгцүүлээд эхэлж болох байхгүй юу. Тэгээд зэрэг гэдэг энэ зүйлээсээ болоод хэлэлцээрийг хүчин төгөлдөр болох нөхцөлийн нэг нь хангагдсан ч юм шиг хангагдаагүй ч юм шиг ийм сонин юм руу орчихно. Тэгэхээр энэ зүйлүүд дээ зааглаж ялгаарай гэдэг зүйлийг хэлье.

Би Дэлгэрсайхан сайдтай санал ижил байна. Энэ 11 дүгээр зүйл дээр тэр гадаадад боловсон хүчин сурах энэ тэр асуудал дээр тусахгүй байж болно. Тэгэхдээ протоколд үлдэг. Ер нь зүгээр энэ компани бол маш том судалгааны институттай учраас сайн хэдэн залуучуудыг ч гэсэн химийн инженерээр бэлдээд авах ёстой юм болов уу л гэж бодсон юм. Эднийд бол нүүрсний энэ баяжуулалт гэдэг юм уу нүүрсээр цаашдаа судалж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх маш том баазтай юм байна лээ. Энэ нүүрсийг чинь нөгөө конвей зони болоод энэ бүх янз янзын спортын хэрэгслүүд хийдэг ч үйлдвэрүүдийг эд нар оруулчихсан байх жишээтэй ч гэдэг юм уу. Маш олон ийм зүйл байна лээ. Тэгэхээр энэ дээр суралцаад аваасай гэдэг үүднээс хэлсэн юм. Тэгээд яах вэ тэндээс орон сууцжуулалтын бодлого энэ тэр гээд нэг ийм жижигхэн юм бараг байх хэрэггүй дээ. Энэ юу гэсэн ч үг юм тэгээд ойлгомжгүй болчихно.

Ер нь тэгээд Нямбаатар гэдэг хүнийг ХЗДХ-ийн сайдаар хийж байсан протоколыг харна биз дээ? Яах вэ тэнд хүрч ажиллаж энэ хэлэлцээрийн удирдамж орж ирээгүй л байна. Тэгэхдээ би зарчмыг нь дэмжиж байна. Тэрэн дээр нүүрсийг хилийн үнээр бүтээн байгуулалтын явц дээр ганц юм Гашуун сухайт. Дараа нь хэлэлцээр бүтээн байгуулалт явсны дараа хилийн үнээр гэж л бид нар шахаж айлын талыг нэлээн л зүтгэж л байсан. Тэгээд энэ дээрээ тэгээд болоогүй л бололцоотой байна. Мэдээж энэ хэлэлцээр амаргүй байдаг. Нөхцөл байдлуудыг ингээд удаашрах тусам л ашиг алдагдлын янз бүрийн юм яриад ирэхэд хэцүү. Тэгээд энийгээ бас манай Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн ойлгож байгаа байх аа. Тэгээд хэдүүлээ энэ ийм зүйлүүдийг ямар ч байсан дэмжээд урт хугацаандаа Монголын экспортын гол бүтээгдэхүүн болох энэ нүүрсийг урт хугацаандаа борлуулах гэрээг баталгаажуулна гэдэг бол манай улс улсын эдийн засагт ч гэсэн цаашдаа анхаарах

юм байгаа. Тэгээд Туваан сайд тэр та хэд маань анхаарч орж ирэх ёстой юман дээр 2023 оны нэг тогтоол байсан. Тэрийгээ уг нь зарим зүйлүүдээ нийцүүлээд яах л байж дээ. Энийг зүгээр хэлэлцүүлгийн явцад цаашдаа хэдүүлээ анхааръя аа. Тэгээд энэ улс орныг авч явж байгаа уул уурхайн салбарт салбарын нийт энэ зүтгэж яваа хамт олон ААН байгууллагууддаа бас энэ уул уурхайн салбарын 102 жилийн мэндийг хүргэе. Тэгээд та хэдийнхээ нуруун дээр энэ улс эх орны эдийн засаг тогтож явж байна аа. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж энэ байгалийн баялгаасаа ард иргэд нь хишиг хувиа хүртдэг энэ зарчим илүү ил тод болоосой эх орны эдийн засаг өндийж тэлээсэй гэж хүсэлтэй байгаа гэдэг зүйлээ эцэст нь хэлье ээ. Тэгээд та бүгдэд амжилт хүсье.

Р.Сэддорж: Баярлалаа Бадрахын Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Монгол улс 1956 оны 1 сарын 1-нд Замын-Үүд Эрээний холболтыг хийсэн байдаг юм байна лээ. Далан жилийн өмнө. Экспортын гол түнш орон эдийн засгийн гол харилцагч оронтойгоо одоо болтол ганцхан төмөр замаар холбогдож байгаа нь үнэхээр харамсалтай явдал байгаа. Тэр байтугай төмөр замаа барьчхаад холбож чадахгүй 10 гаруй жил улс төрийн шалтгаанаар элдэв янзын хутган үймүүлэлтээр санаатай хорлоод, өртөөд, ингээд улсаараа ингээд хохирч байгаа нь үнэхээр харамсалтай байгаа. Энэ асуудал бол угаасаа улс төрийн зорилгоор унагааж ирсэн, гацааж ирсэн, хорлож ирсэн асуудал болохоор Улсын Их Хурлаас өөрөөр хэлбэл улс төрчдийнх нь хүрээнд улс төрийн хувьд ийм шийдвэр гаргаад хэлэлцээр хийх эрх чиглэл өгсөн нь зөв өө гэж бодож байна. Яах аргагүй зөв. Тийм болохоор энэ дээр миний хувьд ч болон ХҮН намын хувьд бол бүрэн дүүрэн энэ хэлцлийг харин аль болох алдаа багатайгаар маш сайн цаг алдахгүй хийх ёстой гэдэг дээр дэмжиж байгаа. Зүгээр ганц нэг зүйл байна.

Тэр 11 дүгээр зүйлд байгаа сэргээгдэх эрчим хүч болон өөр тэр говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх гээд асуудлуудыг оруулчихсан байна л даа. Эндээс тэр сэргээгдэх эрчим хүчний экспорт үнэхээр чухал зүйл. Яг энэ хэлэлцээрийн агуулгад нийцэх зүйл гэж бодож байна. Хэзээ ч ийм юм Монгол Улс өмнө нь ярьж байгаагүй миний мэдэхээр. Тэгэхээр урд хөрш рүү сэргээгдэх эрчим хүчийг экспортлох тухай урт хугацааны итгэлцэл энэ гэрээнд оруулах нь үнэхээр чухал гэж бодож байна. Эрчим хүчний нүүрсний экспорт ч гэсэндээ. Харин энэ бол Засгийн газрын хоорондын хэлэлцээр. Энэ дээр боомтын энэ хэлэлцээрийн агуулга нь боомтын төмөр замын бүтээн байгуулалтыг дэмжих тухай шүү дээ. Тэрэнд чиглэл өгөх тухай. Тэгэхээр яг ингээд хэлэлцээрийн агуулгадаа нийцсэн зүйлсийг Их Хурлаас тогтоож өгөхгүй бол хажуугаар нь зүгээр гишүүдийн саналаар бид нарт хүсэл хэрэгцээ их байна л даа. Усжуулчихмаар байна шар шороон шуургатай тэмцчихмээр байна, боловсон хүчнээ бэлдчихмээр байна өөр юу гэдэг юм жижиг сажиг том юмнууд зөндөө байгаа.

Тэр болгоныгоо ингээд гишүүд болгоны саналаар ингээд чихээд байх юм бол энэ чинь нөгөө хэлэлцээрийнхээ үндсэн зорилгоо алдаад саармагжуулаад үр дүнд нь нөлөөлчих вий дээ. Тийм болохоор миний хувьд санал бол Туваан сайд болон ажлын хэсгийнхэн анхаараасай гэж хүсэж байгаа. Гол хэлэлцээрийнхээ агуулгад төвлөрөөд тэр лүүгээ чиглээд үр дүнгээ тэндээсээ авахгүй бол хажуугаар нь баахан юмны ийм юу гэдэг юм хүслийн жагсаалт аваачаад хэлэлцээрт оруулчих вий дээ. Тэгэхээр гол нь тэрэн дээр л төвлөрөх ёстой гэж бодож байна. Харин энэ дээр давтаад хэлэхэд сэргээгдэх эрчим хүчний экспортын тухай бол заавал тодорхой тусгах юм энэ бол харин ёстой жинхэнэ хэлэлцээрийн агуулгын чухал хэсэг байх болно. Цаашдаа ч гэсэндээ үр дүн маш сайтай зүйл байх болно. Тийм болохоор ямар ч гэсэн энэ хэлэлцээрийг цаг алдахгүйгээр хурдан хийх нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт татах цааш цаашдаа ганцхан боомтоор биш олон боомтоор төмөр замыг холбох ер нь бол ингээд олон 10 жилийн Монгол Улсын эдийн засгийн

өсөлтийн суурийг тавих гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр яаралтай цаг алдахгүй хийхийг дэмжиж байна аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Төслийг дэмжиж байгаа. Тэгээд сая гишүүдийн хэлж байгаачлан тэр боловсон хүчин бэлдэх асуудал чухал байгаа юм. Манай улс орны хувьд нарийн мэргэжлийн боловсон хүчнүүдийг бэлтгэх тэр хамтрагч талаас суралцах энийг бол гэрээнд оруулдаггүй юм гэхэд энийг маш сайн хэлэлцээрийнхээ түвшинд оруулж явах хэрэгтэй. Цаашлаад нүүрсийг олборлох экспортлохоос гадна нүүрснээс өөр ямар боломжуудыг эрэлхийлж болох вэ гэдэг судалгаа хийх, устөрөгч гаргах өөр ямар бүтээгдэхүүн нүүрснээс гаргаж болох вэ сорчилж хэрэглэхээс гадна бусад төрлийн нүүрсүүдээ хэрхэн ашиглах вэ гэдэг дээр судалгаа хийх тал дээр анхаарч ажиллаарай гэдгийг захиж хэлье.

Ер нь бол бид нар энэ ажиллах хүчний хомсдолд ер нь бодитойгоор орчхоод байгаа учраас тэр хүнээ сургая бэлдье ээ гэдгийг хэлээд байгаа. Дэлгэрсайхан сайд таны яриад байгаа хандлага жоохон зохимжгүй байна шүү Засгийн газрын гишүүний хувьд. Одоо энэ чинь Туваан сайд шиг л ингэж ажилламаар байгаа юм. Юмыг хийе, болгоё бүтээе, энэ юм руу ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Тэгээд энэ ажлаа сайн хийгээрэй дэмжиж байна. Тэгээд саяын тэр боловсон хүчнийг бэлтгэх, хүн бэлтгэх, нүүрснээс өөр бүтээгдэхүүн гаргах асуудал руу судалгаа хийх асуудалд энэ яам анхаармаар байгаа юм. Тэгээд дашрамд нэг зүйлийг хэлье. Одоо энэ Оронагийн төсөл давхар орж ирж байна. Хүмүүсийн тархи толгойг худлаа мэдээллээр угаадаг худлаа тэгж улс төржүүлдэг байдлыг таслан зогсоомоор байгаа юм. Өмнө нь хурал дээр Туваан сайдад хэлж байсан. Тэгээд энэ асуудлыг нэлээн анхаарахгүйгээс болж хэн нь үнэн яриад байгаа юм, хэн нь худлаа яриад байгаа юм. Хэн нь жинхэнэ баатар юм. Хэн нь жинхэнэ урвагч юм бэ гэдэг нь мэдэгдэхээ больчихсон. Хэн тэр алдагдсан боломжийг бий болгосон юм, хэн гацаасан юм, ямар шийдвэр энэ ажлыг урагш нь явуулаагүй юм гэдгийг ил тод зарлаж мэдээлэх хэрэгтэй.

Р.Сэддорж: Баярлалаа. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Улс төр байхгүй, эрх ашиг огт байхгүй тийм байдлаар хэдэн зүйлийг анхаараасай гэж та бүхэндээ протоколд тэмдэглүүлж хэлэх хүсэлтэй байна. Энэ урд талаас ирсэн Хятадын талаас ирсэн албан бичиг дээр оруулснаар бол коксжих нүүрс авах ийм хүсэлтэй байгаа гэж байгаа. Тавантолгойн нүүрс 3 талын нүүрстэй, коксжих, сул коксжих, эрчим хүчний. Аль нэгийг нь аваад байж болдоггүй. Ялангуяа 20 сая тонн гэдэг маш их. Ганцхан тэрийг нь аваад байх юм бол бусдыг нь авах боломжгүй болоод ордоо эвдээд технологийн хувьд баялаг хаягддаг юм. Тийм болохоор энэ чиглэл дээрээ 3 төрлийн нүүрсийг нь ашиглана гэдэг зүйлийг анхаарах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь Монголын нутаг дээрх тээврийг Монголын тал хариуцах нь зүй ёсны зүйл ээ уг нь бол. Энэ тээвэр чинь техникийн болоод дэд бүтцийн цаг уур шуурганы тэгээд нөгөө босдог барьдаг янз бүрийн зам хаадаг улс төрийн эрсдэлтэй. Энэ эрсдэлийг худалдан авагч талдаа үүрүүлэх нь зохисгүй. Тийм болохоор нөгөө талдаа тээврийн зардлын ашиг нь Монголдоо үлдэх юм бол манай талдаа хэрэгтэй. Авто тээвэр ч бай, төмөр зам ч бай олон улсын тохиргоонууд байдаг. Тэрүүгээрээ тарифаа тохиролцоод явах боломжтой. Түрүүн ярьсан шүү дээ Нямбаатар сайдын хэлэлцээр хийж байх үед хэдэн нөхцөлөөр ярьж байсан гэж.

Гуравдугаарт нь үнийн индексийг хуучин энэ хэдэн компаниудын байгуулсан үнийн зэрэг чинь хэдэн жилийн өмнө суурь үнэ дээр нэмэх нь 5 өөр үнийн мэдээг ашиглаад

индексийг нь нэмээд хувиараа жигнэж гаргадаг. Энэ тавынх нь дийлэнх нь БНХАУ-ын хойд төв хэсгийн нүүрсний үнийн мэдээ өөрөөр хэлбэл Монголын талаас хөнгөлөлттэй нийлүүлэх нүүрсний хэмжээ огцом нэмэгдэхээр тэр зах зээлийн үнэд тогтдог. Энэ индексүүд дээр нөлөөлнө гэсэн үг. Өөрийнхөө буцаагаад ашиглах үнийн индексийг унагааж байгаад тэр индексээр бодох нөхцөл үүсэж байгаа.

Тэгэхээр мэдээж шаардлагатай хэрэгтэй. Гэхдээ энэ цаг үе нь өөр болчихсон болохоор суурь үнэ нь өнөөдөр өөр. Үнэ бодох индексийн нөлөөлөл нь өөр. Тийм болохоор Хятадын зүүн өмнөд болон олон улсын индексүүдийг хольсон байдлаар томъёогоо шинэчлэх ийм бодитой хэрэгцээ шаардлага байгаа.

Дараагийнх нь 20 сая тонн нүүрсийг нийлүүлнэ ээ гэж. Тэгэхээр одоо энэ боомт маань холбогдоод дараагийн боомтууд холбогдсоноороо нийт экспортын хэмжээ энэ танилцуулга дээр дурдсанаар 120 сая тоннд хүрнэ ээ. 120 хүрч байхад 20 байтугай ч гаргасан болно. Айгаад байх юм байхгүй. Гэхдээ 120 хүрэхгүй бол яах вэ. Дэлхийн янз бүрийн байдлаас болоод Хятадын нүүрсний импорт унах юм бол Эрдэнэс Тавантолгой компанийн олборлодог нүүрсний талаас илүүг хөнгөлөлттэй үнээр нэг компани авна гэсэн үг. Тэгэхээр зөвхөн Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрсний үнэ болоод төдийгүй Монгол Улсын нийт нүүрсний үнэ унах эрсдэл байна. Тийм болохоор боломж байдаг бол Чайна Энержи компанид нийлүүлэх нүүрсний хэмжээ нь 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр гэрээ хийх гээд байна шүү дээ бид чинь. Хятад улс руу нийлүүлэх нийт нүүрсний хэмжээний 20 хувь гэдэг үнэхээр 120 сая хүрчих юм бол 20 хувь чинь 24 сая тонн л байхгүй юу. Ийм зүйлийг анхаараасай гэж хүсэж байна.

Төгсгөлд нь би нэмэлт нэг минутаа авчихъя. Төгсгөлд нь бирж ажилласан. Одоо 400 гаруй компани бүртгэлтэй байгаа. Зах зээл уначихсан учраас татан авалт нь түр зогсчихсон байгаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Нэг минут байхгүй юм байна. Үгэн дээр. Сая нөгөө ирцээрээ орчхож байгаа шүү Батнайрамдал гишүүн. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Баярлалаа өглөөний мэнд хүргэе. Нэг зүйл ойлгомжтой. Тэр нь энэ удаагийн энэ Улсын Их Хурлын тогтоолоор Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын энэ бүтээн байгуулалт явснаараа Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө талаас аваад үзсэн ч гэсэн магадгүй бид нарын 10 жилд байгуулагдах хамгийн чухал гэрээний нэг болох байх. Тийм болохоор дараагийн 10 жил, 20 жилдээ ч яригдах байх. Тийм учраас энэ дээр маш нухацтай хандах ёстой. Тэгэхээр ерөөсөө сүүлийн бараг 20 жилийг ингээд аваад үзэх юм бол Монголын улс төр ч бай ерөөсөө хэдхэн мега төсөл л тойроод явж байсан. Эрдэнэтээс эхэлж байсан шүү дээ. Монгол Улсыг 40 жил тэжээсэн Эрдэнэт үйлдвэрийг дагаж улс төр нь явдаг байсан. Яагаад гэх юм бол тэнд тэрбум доллар гарах мөнгөний урсгал нь л тэнд явдаг байсан. Дараа нь Оюу Толгой байна. Тэгээд Эрдэнэс Тавантолгой. Энэ томоохон төслүүд бол ер нь бүгдээрээ ингээд цэгцрээд явж байгаа. Одоо ерөөсөө ганцхан үлдсэн том төсөл нь ерөөсөө л төмөр зам болчихсон байгаа.

Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой гэдэг энэ том орд өнөөдөр ямар том ач холбогдолтой байсныг бид нар бүгдээрээ ойлгодог болсон. Энэ төслийг дараагийн шатад гаргах зүйл нь ерөөсөө л хамгийн боомилж байсан зүйл нь одоо төмөр зам байгаа юм. Тэгэхээр энэний ард нь зүгээр нэг статистик хэлэхэд эндээс ойлгомжтой болно л доо. Одоо өнөөдөр бид нар нүүрсээ машинаар тээвэрлэхэд өнөөдөр ойролцоогоор нэг тоннд уучлаарай 30 доллар. Энэ ковидын үед бүр нүүрснээсээ илүү үнэтэй болж байсан шүү дээ 100 доллар хүрч байсан байхгүй юу. Өнөөдөр төмөр зам ашиглалтад орох юм бол энэ 100 доллар, 30 доллар хүрч

байсан тээврийн зардал маань 8 доллар хүртэл буух боломжтой болох юм. Тэгэхээр ерөөсөө эндээс эдийн засгийн үр өгөөж нь ямар том ач холбогдолтой байж болох нь аягүй ойлгомжтой харагдаж байгаа биз.

Тэгээд дээрээс нь энэ нь өөрөө хэдэн тэрбум долларын бизнес байж болох нь ойлгомжтой харагдаж байгаа. Тийм учраас л ерөөсөө дандаа улс төр энийгээ дагаж тойрч явж байсан. Тэгээд бид нар энэ төмөр замын хэрүүлээсээ болоод бүр Ерөнхийлөгч хүртэл сонгож байсан шүү дээ. Тэгэхээр энэ гэрээн дээр аягүй чухал зүйлүүд энэ үндсэн чиглэл дээр чухал зүйлүүд орж ирж байна.

Нэгдүгээрт гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлнэ ээ гэж байгаа юм. Гуравдагч талын оролцоо байснаас болоод улс төржиж энэ нь буцаад улс төрөө унагаж энэ буцаад гэрээгээ унагаж ирсэн байхгүй юу. Тэгэхээр энийг үндсэн чиглэл дээрээ ороод гэрээн дээрээ маш ойлгомжтой тусгаж өгөх нь маш зөв. Магадгүй энийг явуулах хамгийн том гаргалгаа энэ дээр байгаа. Тэгээд дээрээс нь бас ярьж байна л даа. Энэ ер нь Хятадын талаасаа ч гэсэн.

Р.Сэддорж: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Ингээд дөнгөж анхны хэлэлцүүлэг Байнгын хороогоор орж байна. Хэлэлцэх эсэх талаар ярьж байна. Санал хураалтыг томьёолж хэлье. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт.

78.99 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Пүрэвийн Батчимэг гишүүний төхөөрөмж ажиллахгүй байсан тул дэмжсэнээр. Алдаржавхлан гишүүн мөн төхөөрөмж ажиллахгүй байна. Техникийн ажилтнууд энэ дээр анхааръя.

Санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал гишүүнийг дэмжих үү? Батнайрамдал гишүүн танилцуулна аа.

Дараа нь Батчимэг гишүүнийг. “Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэх хэлэлцүүлэг дууслаа.

11.57 цагт

Дараагийн асуудалдаа орёе. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг нээе. 3 номер.

Н.Учрал: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан суурь зарчимд нийцүүлэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан билээ. Уг хуулиар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын асуудлыг хуульчлан тогтоосон.

Тодруулбал Ирээдүйн өв санд АМНАТ-өөс Төсвийн тогтворжуулалтын болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг, хуримтлалын сандуул уурхайн олборлолт ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьд ноогдох ноогдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш шударга хүртээх, тэдгээрийн боловсрол, эрүүл мэнд, орон сууцын хэрэгцээнд зарцуулж байхаар зохицуулсан болно. Эдгээр сангуудын эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн хуульд өөрөөр тусгасан. Тухайлбал Ашигт малтмалын хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасан байна аа. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшилд ноогдох орлогыг иргэдийн хадгаламжийн хуримтлалын санд төвлөрүүлэхээр тусгаж, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээх агуулга зарчимд нийцүүлсэн байдаг аа. Харин Ашигт малтмалын хуулийн 47.², 47.³-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр орлуулж болохоор зохицуулж тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газар тогтоож орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх зохицуулалттай байна аа. Энэ нь Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан зарчим түүнд нийцүүлэн гаргасан Үндэсний баялгийн сангийн орлого бүртгэх гэх зарчимтай нийцэхгүй байгаа юм аа.

Ард иргэдийн хуримтлалын санд төвлөрүүлэх орлогын эх үүсвэр стратегийн ордын 34 хувийн төрийн эзэмшлийн 5 хувиас хэтрэхгүй АМНАТ-аар орлуулж байгаа нь учир дутагдалтай байгааг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд олон нийт шүүмжилж байна. Иймд Цөмийн энергийн хуульд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулахдаа илүү үр ашигтай хувилбарыг Засгийн газрын мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болохоор заасантай ижил зарчимд нийцүүлэх шаардлагатай. Иймд Монгол Улсын үндсэн хуулийн зарчимд нийцүүлж хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний баялгийн сангийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Ашигт малтмалын хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон цөмийн энергийн

хуулийн 20.¹, 20.⁵-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр цөмийн энергийн хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаар бий болсон татварын бус орлогыг хуримтлалын санд төвлөрүүлэхээр нэмж тусгаж байна аа. Тус хуулийн төслийг дагалдуулан Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Ашигт малтмалын хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэхээр заасныг өөрчилж, хуримтлалын санд төвлөрүүлэхээр зохицуулалтыг тусгалаа. Түүнчлэн тус хуулийн 47².3-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхгүй байхаар заасныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох зарчимд нийцүүлэн тусгалаа. Эдгээр хуулийн өөрчлөлтөөр байгалийн баялгаас олсон орлогыг иргэдийн хуримтлалын сан хадгаламжаар дамжуулан иргэдэд тэгш шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах боломж бүрдэнэ ээ.

Үндэсний баялгийн сангийн асуудал нь мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.3-д заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал юм аа.

Та бүхнийг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Наранмандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө.

Сайнзориг гишүүнээр тасалж байна. Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 47.3 дахь заалтыг хүчингүй болгохоор орж ирсэн байгаа. Тэгэхээр 47.5 дахь заалт маань яах билээ гэдэг нэг ийм асуулт байгаад байна.

Хоёрт нь болохоор энэ татварын бус орлогыг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж байгаа учраас орон нутгийн хөгжлийн санд очих ёстой байсан орлогод нөлөөлөх үү гэдэг ийм асуулт байгаад байна. Ер нь болохоор Монгол Улс өөрөө хайгуул хийгээгүй байсан ч гэсэндээ тухайн ордынхоо 34 хувийг эзэмших эрхтэй байгаа шүү дээ. Тэгвэл бид нар давуу эрхтэй 10 хувь болгож байгаа тохиолдолд яг ямар давуу тал бид нарт ирж байгаа вэ гэдэг дээр аягүй сайн анхаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл энэ коронагийн юуг харахаар Монгол Улсад очиж байгаа нийт үр өгөөж гэдэгт болохоор тэртээ тэргүй ямар ч компани төлөх ёстой байсан нийгмийн даатгалын шимтгэл, усны төлбөр гээд ч юм уу, үл хөдлөхийн татвар гээд байх ёстой зүйлийг оруулчихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү байдлаар тооцож байгаа бол энэ жоохон буруу байна гэж харж

байгаа юм. Гол давуу талыг нь харахаар бол яах вэ зүгээр орон нутгийн санд 1 сая доллар жил болгон өгч байгаа бол ашиглалтад орсны дараа өгч байгаа бол нэг давуу тал гэж харагдаж байна шүү дээ. Тэгээд энэ компани чинь зүгээр тооцооллоор харахад 10 жилийн дараа хугарлын цэгтэй хүрээд ашигтай ажиллаж эхлэх юм бол бид нар энэ гучаад жилийн хугацааны борлуулалтын орлого ярьж байна.

10 дахь жилээс эхлээд жил болгон 2500 тонн уран олборлож борлуулах юм байна. Тэрнийхээ үр өгөөжөөр тооцох юм бол 34 хувь үр ашиг нь бараг Монгол Улсад илүү үр ашигтай юм биш үү гэж бодогдож байна аа. Энэ тал дээр нэлээн тайлбар авъя аа. Бид нар 34 хувиа яагаад давуу эрхтэй 10 хувиараа сольж байгаа юм бэ? Тэрний гол давуу тал нь юу юм бэ гэдэг дээр тодорхой тайлбар хүсэж байна аа.

Р.Сэддорж: 3 номер. Учрал сайд.

Н.Учрал: Монгол Улсын Үндсэн хууль 2019 онд батлагдсан нэмэлт, өөрчлөлт. 6.2 дээр газрын хэвлийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ ээ гэдэг чинь 50 дээр нэмэх нэг л гэсэн үг л дээ. Үүний дараа хэрхэн энэ 50 дээр нэмэх нэгээ хангуулах юм бэ гэдгийг арга зам механизмыг Үндэсний баялгийн сангийн хуулийг өнгөрсөн парламентад батлаад баталгаажуулсан. Үндэсний баялгийн сан дэргэдээ 3 сантай. Ирээдүйн өв сан бол ирээдүй хойчдоо өвлүүлж байгаа санхүүгийн хэрэгсэлд оруулж болох ийм хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн. Хуримтлалын сан гэдэг бол эрүүл мэнд боловсрол орон сууцад зарцуулагдаж байгаа иргэдийн хадгаламж. Үүнтэй холбогдуулаад өнгөрсөн нэг жилийн хугацаанд 480 орчим тэрбум төгрөгийг төрийн өмчийн.

Р.Сэддорж: Учрал сайд гүйцээж хариулья.

Н.Учрал: Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хуульд заасан энэ 3 сангийн хуримтлалын сан бол өөрөө энэ төрийн өмчит уул уурхайн компаниудын 34 хүртэлх ноогдол ашиг хуримтлагддаг сан. Үүнтэй холбогдуулаад сая тэр 480 тэрбум төгрөг ба баялгийн сангийн хууль батлагдсаны дараа 5 уул уурхайн компани энд хуримтлал үүсгэснээс тэгээд дараа нөгөө иргэд И Монгол дээр тэр 235 мянган төгрөгийн хадгаламжийг хардаг болсон. Тэгээд цаашдаа бид нар юу вэ гэхээр Баялгийн сангийн хуулийг амилуулахын тулд энэ явж байгаа төслүүдийн ноогдол ашиг хуримтлалын санд хуримтлагддаг болсноороо энэ иргэдийн хадгаламж өсөх ёстой. Тэгж байж тэр ипотектоо хамрагдана, тэгж байж тэр эрүүл мэндийн үйлчилгээ. Тэгж байж тэр боловсролын үйлчилгээг авна.

Тэгэхээр энийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр л бид нар гол анхаарлаа хандуулсан. Үүнтэй холбогдуулаад Үндэсний баялгийн сангийн хуулийг дагалдуулаад энэ Ашигт малтмалын хууль дээр тэр тусгай АМНАТ-аар хэрвээ орлуулж байгаа бол тусгай АМНАТ-аар орлуулж байгаа хуримтлал нь Үндэсний баялгийн сан, тэр дотроо хуримтлалын санд очих ёстой. Гэтэл өнөөдөр Ашигт малтмалын хууль дээр улсын төсөвт төвлөрүүлнэ ээ гэдэг заалттай. Баялгийн сангийн хуулиар хуримтлалын сангийн орлогын эх үүсвэр дээр хэрвээ 34 хүртэлх хувийг Их Хурал тусгай АМНАТ-аар эсвэл бүтээгдэхүүн хуваахаар орлуулж байвал тэр орлуулж байгаа хэсэг нь ч гэсэн иргэдийн хадгаламж хуримтлал руу очих ёстой шүү гэдгийг нь хуулиар нээж өгч байгаа гэсэн үг. Нэгэнт 34 хүртэлх ноогдол ашгийг нь төр эзэмшээд үүнийг нь хуримтлалын санд хийж байсан. Гэтэл бид нар өнөөдөр нөгөө Их Хурал АМНАТ-аар орлуулах, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах энэ эрхийнхээ хүрээнд Их Хурлын тогтоолоор шийдэж байгаа учраас.

Тийм учраас бид нар энэ Францтай хийж байгаа хөрөнгө оруулалтын гэрээн дээр нэг л зарчим барьсан. Ерөөсөө л Үндсэн хуулийн суурь зарчмаа хангуулъя. 50 дээр нэмэх 1. Тэгвэл Засгийн газрын хүртэж байгаа хуримтлалын үр өгөөжид юу юуг хамааруулах вэ гэдэг дээр л гол хэлэлцээр явж байгаа. Тэгэхээр бид нар эхлээд энэ тохиолдолд сая Соронзонболд гишүүний хэлж байгаагаар бид нэг л зарчим ярина аа. Үүн дээр ОУВС-аас гаргаж байгаа уул уурхайн эрдэс баялгийн салбарын төсөл хөрөнгө оруулалтаас авч байгаа энэ өгөөж дээр ямар зарчим барих вэ гээд аргачлалаа тохирьё гэдэг саналыг тавьсан. Аргачлал бол Засгийн газрын хуримтлагдсан үр өгөөж дээр хөрөнгө оруулагчийн хуримтлагдсан үр өгөөжийг нэмээд хөрөнгө оруулагчийн олгосон санхүүжилтийг хасахаар 51 хувьдаа хүрч байх ёстой.

51 хувьдаа хүрээгүй байгаа тохиолдолд яах вэ гэдэг асуудал яригдаж байсан учраас 1 дүгээр зарчим бол бид өөрсдийнхөө санхүүгийн схем моделийг боловсруулаад энэ манай санхүүгийн схем дээр ураны тэр нэг фунтийн үнэ нь 50 байхад, 80 байхад, 100 байхад, 50 дээр нэмэх 1-ийг хангуулах уу гэдэг зарчмаа яриад санхүүгийн схемээ тулгасан, шаардлага болгож тавьсан. Ингээд бүх төрлийн хэлбэрээр манай санхүүгийн схем дээр энэ 50 дээр нэмэх 1 хангагдаж байх ёстой гэдэг зарчмаа барьсан. Энэ хүрээндээ нийтдээ.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Би аягүй тодорхой асуусан шүү дээ. Ашигт малтмалын тухай хуулийн 47.3-ыг хүчингүй болгож байгаа юм бол 47.5 дахь заалт чинь яах юм бэ гэж эхлээд асуусан шүү дээ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт болохоор би гол нь хэлээд байгаа байхгүй юу. Монгол Улсын нийт үр өгөөж гэдэгт одоо тэртээ тэргүй ямар ч компани Монголд хөрөнгө оруулсан байлаа гэсэн том ажилтныхаа НДШ-ээр төлөх л байхгүй юу. Ус ашигласны төлбөрөө төлөх л ёстой шүү дээ. Тэгээд тэрний дараах үр өгөөжийн тухай ярихгүй. Зүгээр ингээд Монгол Улсад орж байгаа нийт үр өгөөжөөр нь бодоод 34 хувиа л давуу эрхтэй 10 хувь болгож байгаа чинь яагаад тэгж байгаа юм бэ л гэж асуугаад байгаа шүү дээ. Яг ямар үр өгөөж ирж байгаа юм бэ гээд байхгүй юу.

Н.Учрал: Ашигт малтмалын хуулийн 47² дахь заалт бол тусгай төлбөрийн асуудал байгаа юм. Тусгай төлбөрийн хэмжээг Засгийн газрын мэдүүлснээр Их Хурал тогтооно. Үүнийг улсын төсөвт биш хуримтлалын санд төвлөрүүлнэ гэдэг заалт өөрчилж байгаа. Баялгийн сангийн хуультай нийцүүлж байгаа.

Дээрээс нь тусгай АМНАТ-ийн босго нь 5 хүртэлх хувь байна гээд заачихсан. Тэгэхээр нөгөө 34-ийг орлуулахаар тусгай АМНАТ-ыг 10-аар ч юм уу, 15-аар ч юм уу цаашдаа төслүүд дээр тооцохоор нөгөө босго нь 5 байгаа учраас өөрчилж болохгүй учраас босгогүй болгоод нэгэнт Их Хурал онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд шийдэж байгаа учраас Их Хурлаар энэ таваа 10 болгоно уу, хэд болгоно уу тухайн тэр төсөл дээр хамааруулаад явъя гэсэн. Өнгөрсөн хугацааны хөрөнгө оруулалтын гэрээний алдаа сургамжийг дахин давтахгүйн тулд бид нар борлуулалтын орлогоос шууд АМНАТ авах нь манайд эрсдэл багатай үр өгөөж юм л гэж тооцсон. Ингэж тооцож байгаа. Дээрээс нь төслийн нийт үр өгөөж дээр яг таны хэлж байгаагаар тэр 50 дээр нэмэх 1-ийг хангуулахын тулд 13 янзын төлбөр татварыг л Засгийн газрын үр өгөөж тооцож байгаа. Жишээ нь ус ашигласны төлбөр ус бохирдуулсны төлбөр ч юм уу агаарын бохирдлын төлбөр ч юм уу энийг бол Засгийн газрын авч байгаа өгөөж гэж огт тооцохгүй байгаа. Нөгөө жишээ нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээн дээр менежментийн төлбөр байдаг. Менежментийн төлбөртэй адилхан

энэ төсөл дээр жишээ нь маркетингийн төлбөр байлаа гэхэд энийг бол зардалд тооцохгүй энэ бол хөрөнгө оруулагч талын үр өгөөж гэж тооцож байгаа юм.

Нэг ёсондоо зардал өсгөөд байдаг ноогдол ашиг авах хугацаа хойшлоод байдгаас салахын тулд ерөөсөө өөрсдийнхөө санхүүгийн схем дээр бид нар суусан. Ингээд 13 янзын төлбөр, татвар дээр л бид нар Засгийн газрын үр өгөөж гэж тооцно оо бусдаар тооцохгүй гэж байгаа. Зүгээр манай энэ хувилбар бол нөгөө ноогдол ашгаас биш шууд биш гол нь 50 дээр нэмэх 1-ээ авна. Тусгай АМНАТ-аар орлуулсан ч бай бүтээгдэхүүн хуваахаар орлуулсан ч бай энэ тэд ашигтай ашиггүй ажиллахаас үл хамаараад шууд борлуулалтаас нь АМНАТ-аа аваад явах нь эрсдэл багатай гэдэг. Ийм эрсдэлгүй үр өгөөжийг бий болгоё гэж зорьж байгаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хуулийн төслийг хэлэлцэхийг зарчмын хувьд дэмжиж байна аа. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтийг дэмжиж байна.

Яах вэ зүгээр энэ 34 хувийг томоохон стратегийн ордууд дээр төр эзэмших ёстой гэдэг. Энэ өөрөө эргээд Монгол Улсын заримдаа эдийн засагт чөдөр болчихоод байгаа юм. Нөгөө бухын доодхыг харж үнэг гэгчээр. Хэзээ ноогдол ашиг нь авч орж ирэх нь мэдэхгүй төслүүдээ хараад суугаад байдаг нэг талдаа. Нөгөө талдаа бид нар энэ бизнесийн зарчмыг нь ойлгомоор байгаа юм аа. АМНАТ-аас гадна яах вэ 34 хувиа эзэмшинэ гээд орчихоор энэ 34 хувийн эзэмшигчтэй холбоотой анхны хөрөнгө оруулалтыг Монгол талаас хийж таарна. Энэ мөнгө бидэнд байдаггүй. Яг тухайн цаг үе дээр. Сая Учрал сайдын үгэнд ч гарч байна. Гэрээний явцад гадна, дотнын, янз янзын нөхцөл байдлууд бизнест эрсдэл болж ирдэг ээ. Үүнээс шалтгаалаад зардал өсөж болно. Энэ бүх зүйлүүд дээр нөгөө 34 хувийн үр өгөөж чинь орж ирэхгүй болохоор иргэд нөгөө байгалийн баялгаас хүртэх ёстой энэ төслүүд чинь яагаад улсын эдийн засагт дэм болохгүй байгаа юм гэдэг ийм шүүмжүүд харагдаад байгаа юм аа. Тэгэхээр энэнээс нэгд нэг талдаа ангижраад уул уурхайн энэ асуудлыг яг бизнесийн зарчмаар явъя. Бид харин зүгээр авах ёстой АМНАТ дээрээс нь яах вэ зүгээр энэ 34 хувийг эзэмших энэ бололцоогоо бид нар тусгай АМНАТ-аар солих энэ асуудлыг цаашдаа явбал хөрөнгө оруулагч талдаа илүү амар болоод явах байх. Монголчууд ч гэсэн эрсдэлгүйгээр үр өгөөжөө шууд тухайн цаг мөчдөө аваад явж байгаа нь илүү зарчмын хувьд зөв гэж үзэж байгаа учраас энийг дэмжиж байгаа юм. Нэг л асуулт л байна. Яах вэ зүгээр ингээд бас энэ зүйлүүдээр ингээд бизнес хэлэлцээрүүд нэлээн явах үүд хаалга нээгдэж байгаа боловч жоохон тодорхойгүй нэг юм үлдэх гээд байгаа нь ер нь зүгээр тусгай АМНАТ-ын доод босго, доод хэмжээ дээшээ явж очих босго чинь юу юм бэ гэдэг дээр магадгүй хөрөнгө оруулагч нар асууна. Энэ дээр манай Засгийн газар гэдэг юм уу яамдуудаас хариулах цэггүй л болчихлоо.

Одоо хэлэлцээрийн хувьд Улсын Их Хурал ороод шийднэ гэнэ. Яг энэ дээр нөгөө эдийн засаг тооцоо судалгааны хувь дээр хийхэд жоохон хүндрэлтэй зүйлүүд гарна аа. Тэгэхээр уг нь бололцоо байдаг бол энэ тусгай АМНАТ-ын доод босго эсвэл дээшээ хэд хүртэл явж болох вэ гэдэг зүйлийг уг нь нэг жоохон хайрцагтай байвал зүгээр юм болов уу гэж зүгээр би хувь гишүүний хувьд л бодож байгаа юм шүү. Тэгээд энэ магадгүй дараа нь нөгөө хэлэлцээр хийх албан тушаалтнуудад амар байх. Нэг тоо тавиад ороод ирдэг бас ингээд хардалт дагуулаад явчих вий л гэдэг зүгээр ийм болгоомжлол байгаа юм. Тэгээд энэ дээр Учрал сайд ямар байр суурь байгаа юм. Ер нь зүгээр зарчмын хувьд энэ хуулийн төслүүдийг дэмжиж байна. Зүгээр доод босго тавих эсвэл дээшээ таазыг нь тавьж өгөх энэ

асуудлууд дээр шаардлага байгаагүй гэж үзэж байгаа үндэслэлээ та нэг тайлбарлаад протоколд үлдээгээч ээ. Энийг мэдээж тухай бүрдээ хэлэлцээр явж шийдэж болно.

Р.Сэддорж: 3 номер Учрал сайд.

Н.Учрал: Олон жил бид нар байгалийн баялаг ард түмэн эзэмшинэ гэж ярьсан. Тэгэхдээ арга зам механизм огт тодорхой байгаагүй. Ер нь бол Монгол Улс өнгөрсөн хугацаанд нэг ч удаа өөрсдөө санхүүгийн схем боловсруулаад өөрсдийнхөө санхүүгийн схем дээр 50 дээр нэмэх 1-ийг нь хангуулаад бүх хувилбараар тэр таамаглалыг бий болгож байгаад яг үнэлж байсан тохиолдол төдийлөн байхгүй шүү дээ. Тэгээд дэлхийн хэмжээний үндэстэн дамнасан ийм том компаниудтай хэлэлцээрт ороод тэгээд бид нар ингээд 50 дээр нэмэх 1-ээ хангуулна гээд суугаад байна гэдэг бол эрсдэлтэй.

Тийм учраас бол энэ удаагийн энэ хөрөнгө оруулалтын гэрээ юугаараа жишиг болох вэ гэвэл бид нар өөрсдийнхөө санхүүгийн схем дээр бүх таамаглалуудыг дэвшүүлсэн, нийт өгөгдлүүдийг цуглуулсан. Ингээд тэр олон улсын тэр фаст гээд байгаа стандартыг барьсан дээрээс нь анх удаа бенефит теражастмент гээд байгаа тохируулга хийсэн. Тохируулга хийнэ ээ гэдэг энэ бол жилийн үр өгөөж Монголын ард түмэнд 50 дээр нэмэх 1-ээр оногдохгүй байвал түүнийг нь нөгөө компаниас гаргуулж 51 хувь хүргэх тэр тохируулгыг хийсэн. Нэг ёсондоо жил болгон бид нар 50 дээр нэмэх 1 хүрээгүй байгаа тохиолдолд жишээ нь 1 хувь дутвал тэр 1 хувийг хөрөнгө оруулагч талаас тохируулж 51 хүргэх энэ тэр тохируулгыг хийж өгснөөрөө бол энэ онцлогтой.

Хоёрт бол нөгөө Засгийн газар хуримтлагдсан үр өгөөж гэж юуг хэлэх юм бэ гэхээр шууд үр өгөөж гэж байгаа юм. Шууд үр өгөөж бол тэр төлбөр, татварууд. Шууд бус үр өгөөж гэдэг бол нөгөө ажлын байрыг нэмэгдүүлж байгаа, салбарын үйл ажиллагаанаас ур чадварыг хөгжүүлэх замаар олж байгаа тийм өгөөжүүд.

Гуравт бол нөгөө дам өгөөж. Дам өгөөж гэдэг бол тэнд мэдээж нэмэлт эдийн засгийн үйл ажиллагаа идэвхэжнэ. Худалдаа үйлчилгээ бусад салбар идэвхэжнэ гээд тэр дам өгөөж. Хэрвээ бид нар шууд ба шууд шууд өгөөж шууд бус өгөөж дам өгөөжийг нийлүүлээд 50 дээр нэмэх 1 гэх юм бол шударга бус байхгүй юу. Шууд өгөөж гэдэг бол шууд төсөвт, шууд үндэсний баялгийн санд, хуримтлалын санд, Ирээдүйн өв санд, Хөгжлийн санд орж байвал энэ бол шууд өгөөж.

Тийм учраас бидний тохирсон 13 төлбөр татвар бол бүгдээрээ шууд өгөөж гэдгийг бол бас хэлэх ёстой. Шууд өгөөж гэдгийн гол онцлог бол яг тэр борлуулалт дээрээс нь авч байгаа. Тэрнээс биш ноогдол ашгийг хүлээгээд сууна гэдэг бол утгагүй. Нэг ёсондоо зардал нэмэгдүүлээд захирал нь урамшуулал авдаг болчихсон компаниуддаа гээд шүүмжлээд байдаг. Тэгвэл хөрөнгө оруулалтын гэрээ ч гэсэн зардал нэмээд л байдаг, ашиг авах хугацаа нь хойшлоод л байдаг. Тэгээд шилний цаанаас тэр чихэр долоолгоод байна гэдэг чинь юу вэ гэхээр та ингээд ашгаа хүртэнэ ээ удахгүй хүртэнэ гээд л тэр нь хойшлоод л байдаг хойшлоод л байдаг. Тэгэхээр төр 10 хувиа эзэмшинэ. Анх удаа давуу эрхийн хувьцааны 10 хувийг эзэмшихдээ Засгийн газар ТУЗ дээр төлөөлөлтэй хориг тавих эрхтэй санхүүгийн ямар ч хариуцлага хүлээхгүй хөрөнгө оруулга ямар ч хариуцлага хүлээхгүйгээр хөрөнгө оруулалтын гэрээ хийж байгаа нь л сайн жишиг болно гэж ингэж бодож байгаа.

Р.Сэддорж: Тодруулъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Мэдээлэл өгсөнд баярлалаа Учрал сайд аа. Тэгээд гол нь зүгээр асууж байгаа нь энэ л байгаа юм. Нөгөө энэ нөгөө тусгай АМНАТ-ыг 34 хувиа тусгай АМНАТ-

аар солихдоо 5 хувиас хэтрэхгүй гэдэг нөгөө байсан шүү дээ дээд таазтайгаа л байсан. Энийгээ бид хэд ингээд байхгүй болгож байгаа. Тэгэхдээ ингээд доод хэмжээ гэж байж болох уу? Яах вэ дээшээ хэд ч явж болох байх. Энэ нь өөрөө эргээд ер нь дараа нь нөгөө хэлэлцээрүүд дээр орж байгаа институцүүдэд амар байх юм бол уу. Зүгээр энэ дээр тэгэх шаардлагагүй гэж үзсэн юм байна аа. Энэ үндэслэл зүгээр байгаа юу? Зүгээр тэрийг л асуусан юм. Ер нь тэгэхдээ энэ чинь 5 хувиас хэтрэхгүйгээр байсан гэдгээс ер нь зүгээр цаашдын Оронагийн хэлэлцээрээс доод тал нь тусгай АМНАТ 5-аас эхлэх нь. Уран дээр бид нар жоохон өөрөөр хийсэн байхгүй юу. Өсөн нэмэгдэх АМНАТ-тай учраас бас ингээд явчхаж байгаа юм. Бусад ашигт малтмалын юун дээр бас яг энэ чиглэлийн ийм хэлэлцээрүүдийг хийхэд бас нэг ер нь нэг баримжаа байх л үүднээс би зүгээр доод тавиад болж өгвөл яах вэ дээшээ хэд ч байж болох нь Монголчуудад ашигтай учраас хязгаарлахгүйгээр байж болно. Би зүгээр энэ дээр л нэг байр суурийг сонсох гээд байсан юм.

Р.Сэддорж: 3 номер, Учрал сайд.

Н.Учрал: Тийм. Ер нь тусгай АМНАТ-ын дээд босгыг нь 5 гээд тавьсныг яг үнэндээ би бас ойлгохгүй байгаа юм. Хэн хэнд зориулсан ийм босго юм. Тэртээ тэргүй Засгийн газар бие дааж тусгай АМНАТ-ыг шийддэггүй шүү дээ. АМНАТ-аар орлуулах асуудлыг Их Хурал шийддэг байхад тусгай АМНАТ-ын дээд босго нь 5 гээд тавьчихсан. Энийг Их Хурал шийддэг бол тухайн хөрөнгө оруулалтын гэрээнээсээ шалтгаалаад л 5 байна уу, 10 байна уу орлуулаад л явчихвал эцсийн үр дүнд Монголын ард түмэн тэр газрын баялгийнхаа 50 дээр нэмэх 1-ийг л авч байвал ямар арга замаар биш байхгүй юу. Эрсдэлгүй л байх ёстой, эрсдэлгүй. Тэгэхээр тэр доод босгыг жишээ нь магадгүй Их Хурал дээр Сайнзориг гишүүн санал гаргаад ажлын хэсэг дээр доод босго нь 50 түүнээс дээш хэд байхыг нь тухайн хөрөнгө оруулалтын гэрээнээсээ шалтгаалаад Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал АМНАТ-ийг нь шийдээд явах бүрэн бололцоо бол байгаа. Одоо цаашдаа манай энэ уул уурхайн салбарынхныгаа идэвхжилтийг илүү сэргээх, цаашдаа нийгэм ч гэсэн, иргэд ч гэсэн энэ уул уурхайн салбарынхаа гол эдийн засгийг бүрдүүлж байгаа энэ салбарынхад итгэж үнэмших байдлыг сэргээхийн тулд энэ баялгийн сан үүнд маш том нэмэр болох юм байна лээ.

Тусгай АМНАТ-аар орлуулж ирээд л шийдчихвэл жишээ нь тэр И Монгол дээр харагдаад байгаа тэр хуримтлалын сангийн мөнгө нь энэ хэлэлцээр явснаараа таны дансанд тэдэн төгрөг нэмэгдлээ. Таны дансанд таны хадгаламжид энэ уул уурхайн компани гэрээ нь хийгээд ажил нь бүтээн байгуулалтын ажил өрнөснөөрөө таны хуримтлалын санд тийм хуримтлал нэмэгдлээ гэдэг нь харагддаг болох ёстой байхгүй юу. Тэгж байж түүнд итгэж үнэмшинэ. Тэгэхээр ер нь цаашдаа тусгай АМНАТ дээрээ 5-аас доошгүй байна ч гэдэг юм уу ийм өөрчлөн найруулаад оруулчихвал илүү баталгаатай болох бололцоотой. Угаасаа 5-аас доош тусгай АМНАТ авна гэдэг ойлголт ер нь байж болохгүй шүү дээ.

Р.Сэддорж: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Оранотой байгуулж байгаа гэрээ ер нь бол олон улсад зөв тохиолтой. Монгол Улс Учрал сайд Монгол Улс тэгээд хүнтэй нэг юм яриад хийчихдэг юм байна гэдэг нэг хөшүүрэг л дээ. Тэгээд л ухаантай ухаантай юм яриад л, цэц булаацалдаад байхгүй, нэг хэлцэл хийгээд дуусгачихдаг юм байна гэдгийг. Оюу Толгойгоос хойш тийм юм байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ нэлээн тийм давуу талтай. Тэгэхдээ би тэр тусгай АМНАТ 5 хувь гэдгийг 11 онд билүү би сайн санахгүй байна энэ Ганбаатар энэ тэр мэдэж байгаа байх. Энэ бол тэгэхдээ нөгөө талдаа Учрал сайдаа нөгөө талдаа тэр хөрөнгө оруулж байгаа хүн чинь би ямар татвар төлөх вэ гэдгээ хардаг байхгүй юу. Тэгж байж хөрөнгөө

тооцдог. Хамаа замбараагүй бас татвар нь хэдийг ч авах магадлалтай бол тойроод л яваад байна шүү дээ. Тэр чинь өөрөө тэр нөгөө талдаа бол юмыг тоглогчоо их тодорхой болгож байгаа байхгүй юу. Гэхдээ би тэр 5 хувийг нэг их хамгаалаад яриад байгаа юм биш. Ер нь бол тэгэхдээ дээд хязгаар байхгүй бол болдоггүй. Энийг бас Засгийн газрынхан нэг ойлгож аваарай даа. Хэт бас нөгөө тал руу нь гуйвуулж болохгүй шүү. Би энэ 4 номерын даргаас нэг асуулт байна. Энэ гэрээ их сайхан болж байгаа мундаг болж байгаа бүх татваруудаа авч байгаа л гээд байгаа юм. Үгүй ээ энэ нэмэгдсэн өртгийн албан татвар хариулахгүй байгаад байгаа шүү дээ. Сониноор над руу сониноор биш ээ хөөрхий нөгөө хуучнаараа ярьж байна. Хэвлэлээр л над руу хариулт өгөөд л дайраад байгаа юм. Тэгэхээр наад нэмэгдсэн өртгийн албан татвар чинь хамгийн том татвар. Тэгээд наад Оронагийн явуулж байгаа нөхдүүд нь коридорт над руу харахгүй болсон байна лээ. Нүдээрээ бараг зодоод л мөрөөрөө мөрлөх гээд байгаа юм уу яах гээд байгаа юм тэгээд л. Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татвар чинь наад Учрал сайд сая хэлээд байна шүү дээ бүх татвараа авч байгаа гээд. Тэгээд ямар ахилт гаргасан. Наадах чинь эцсийн бүтээгдэхүүн биш ээ гэдгийг тэр ард чинь сууж байгаа доктор бол сайн мэдэж байгаа юм.

Хаана очоод эцсийн бүтээгдэхүүн болох вэ гэдгийг хүртэл сайн мэдэж байгаа юм. Тэгэхлээр наана чинь эцсийн бүтээгдэхүүнд бид нар хөнгөлөлт өгдөг тийм хуультай. НӨАТ-ын буцаан олголт гэдэг бол эцсийн бүтээгдэхүүнд өгдөг. Эцсийн бүтээгдэхүүнийг дэмжиж байна гэсэн үг Монгол Улс. Ямар ахиц дэвшил гарсан бэ гэдгийг сонсьё. Тэр 20 секунд байгаа дээр хэлэхэд бол тэр тусгай АМНАТ-ийн дээд хязгаар гэдэг муу зүйл биш шүү. Хөрөнгө оруулагчдыг юмаа тооцоолоод би энэнээс дээш татвар төлөхгүй байна гэдэг тооцох тэр боломжийг тэр хүмүүст олгож байгаа юм. Тэгэхдээ би 5 хувийг нь хамгаалаагүй шүү.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүний хариулт. Учрал сайд эхлээд дараа нь 3 номер.

Н.Учрал: Тийм. Ганбаатар сайдын хэлж байгаа маш зөв. Яагаад гэхээр 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бид нарт нэг ийм том хэмжүүр тавиад өгчхөж. Нөгөө газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх нэгийг ард түмэн эзэмшинэ гээд хэмжүүр тавиад өгчихсөн. Тэгээд нөгөө Үндэсний баялгийн сангийн хууль батлагдаад арга зам нь тодорхой болчихсон. Тэгээд эхлэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа Монгол Улсын Засгийн газар анх удаа Хөрөнгө оруулалтын гэрээ хийх гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бид нарт нэг ийм шалгуур байгаад байгаа, 50 дээр нэмэх 1-ийг яаж хангуулах вэ л гэдэг энэ заалтыг тойрсон л хэлэлцээр боллоо шүү дээ. Энийг л хангуулахгүй л бол Үндсэн хуулийн зөрчил.

Тэгэхээр бид нар тэр санхүүгийн схемээ анх удаа 50 дээр нэмэх 1 дээр тохируулж хийлээ. Анх удаа 50 дээр нэмэх 1 дээр. Тэгээд нөгөө хэлэлцээр дээр хийхдээ бид нар ийм Үндсэн хуультай энэ 6.2. Энэ 50 дээр нэмэх юм чинь хүрэхгүй байна. Тэгээд санхүүгийнхээ схем дээр тавиад жишээ нь 50 байвал хэд юм, 80 байвал хэд юм нэг фунгийнх нь үнэ. Энэ дээр чинь хүрэхгүй байна шүү дээ гээд ингээд яриад тэгээд тэр чинь нөгөө схем дээрээ таамаглалаа тавиад ингээд яваад байдаг. Анх удаа нэг ийм схемтэй болчихлоо. Энэ бол их сайн жишиг бол болсон. Тэгээд энийг хангуулахын тулд одоо бид нар цаашдаа бүхий л хөрөнгө оруулалтын гэрээн дээр энд 6.2 яригдах нь л дээ. 6.2 тэгэхдээ 1 ийм схемтэй байгаа учраас энийг тавиад явна. Тэгээд анх удаа хөрөнгө оруулалтын гэрээнд энэ тохируулга гэдэг ойлголтыг оруулж ирлээ. Нөгөө 50 дээр нэмэх 1 хангуулахгүй бол хөрөнгө оруулагч тал тэр нөхөж тэрэн дээр тохируулга хийж 50 дээр нэмэх 1 хүргэх. Бид нар ямар ч хөрөнгө оруулалтын гэрээн дээр заавал энийг тавина. Тэгэхээр Ганбаатар сайдын ярьж байгаа энэ тусгай АМНАТ-ын босго ч байна уу мэдээж энэ бол мэдээж хөрөнгө оруулагч талаа харах хэрэгтэй учраас ямар ч байсан нэг ийм Үндсэн хуулийн 6.2 бол бид нарын хувьд том

шалгуур болсон. Тийм учраас л энэ тусгай АМНАТ-ийг нь босохгүй болгоод тэгээд хэлэлцээд явах нь зөв байна гэдэг. Ер нь хувийн хэвшил ч гэсэн хэлж байгаа та нар тогтвортой ажиллуулъя гэвэл хөрөнгө оруулалтын гэрээгээ Их Хурлаар танилцуулаад яв. Гаднынхантай ингэж байгаа бол дотоодын компаниуд ч гэсэн ийм байдлаар баталгаажуулъя аа. Тогтвортой байя аа, хандаач ээ гэж байгаа юм. Зүгээр НӨАТ-ын асуудал бол нэмж тодруулах байх. Гэхдээ НӨАТ-ын асуудал дээр бол бид НӨАТ-ыг НӨАТ-ын тэр 10 хувийг ерөөсөө тогтворжуулаагүй. Засгийн газарт уул уурхайн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн мөн үү биш үү гэж үзэхийг жагсаалтаар засгаар оруулаад шийдэх эрх нь байгаа. Энийг тогтворжуулаагүй.

Тийм учраас хөрөнгө оруулалтын гэрээн дээр бид нар НӨАТ-ын асуудлыг бусад бүтээгдэхүүн дээр адилтгаж авч үзэх юм бол НӨАТ-аа төлөөд явна гэдэг ийм байр суурийг хөрөнгө оруулагч тал илэрхийлсэн. Гэхдээ Монгол Улс нүүрсийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзэж байгаа үед бол шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзэх үү үгүй юу гэдэг асуулт бол эргэлзээтэй. Нүүрсийг л эцсийн бүтээгдэхүүн гэж үзэж байгаа л улс шүү дээ. Тэгээд л НӨАТ-ыг нь буцаан олгож байгаа бодох л ёстой. Тэгэхээр энэ их том улс төр юм байна лээ.

Р.Сэддорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн. 4 номер хариулт.

Х.Наранцогт: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Цөмийн энергийн хуулийн хэлэлцүүлгийн үеэр та энэ асуудлыг нэлээн тавьсан. Тэгээд бид нар энэ хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн үеэр энэ асуудал дээр нэлээн хатуу байр суурьтай энийг ер нь төлжүүлчих тал дээр нэлээн ажиллалаа. Гэхдээ хамгийн гол нь сая Учрал сайдын хэлсэн таныг Уул уурхайн сайд байхад тэр хэвээрээ л байсан. 2015 онд энэ шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гээд оруулчихсан юм байна лээ. Тэгээд энэ танай хууль эрхээр танай бусад компаниуд энэ НӨАТ авч байгаа учраас бид нарыг энэ хууль эрх зүй чинь хүчин төгөлдөр байсаар байтал энийг төлүүлэх гэж шахаж байгаа бол та нар ийм хууль бус зүй бус шаардлага тавьж байна гэдэг асуудлыг зөрүүлж тавьж байгаа. Тэгээд бид энэ дээр ийм асуудал оруулж ирж байгаа. Төсөл хэрэгжүүлэгч компани бол яг энэ гэрээн дээр та бүхэнд тараасан товхимол дээр байгаа. Монгол Улсад НӨАТ төлөх үүргийн хувьд бусад уул уурхайн ААН-үүдээс үл ялгаруулах нөхцөлөөр явагдана гэдэг ингэж тодорхойлж явуулж өгч байгаа юм. Энэ нь өөрөөр хэлэх юм бол та нар энэ өөрсдөө асуудлаа шийдчих юм бол бид нар төлье өө гээд. Энэ яг агуулгаар Монгол Улсын Засгийн газрын шууд өгөөжид орох жагсаалт дотор НӨАТ-ыг оруулчихсан байгаа. Өөрөөр хэлбэл бид өөрсөө өөрсдөө асуудлаа шийдвэл эднийх НӨАТ төлнө. Төлсөн НӨАТ нь манай үр ашигт орохоор. Тэгэхгүй бол хэрэв НӨАТ төлүүлэхгүй гэж байсан бол энэ НӨАТ чөлөөлөгдөнө гэвэл энэ НӨАТ-ыг Монгол Улсын үр ашигт оруулахгүйгээр энэ гэрээнд орох ёстой.

Тэгэхээр энэ бол ер нь нэлээн ахиц дэвшил сайтай ийм тодорхойлолтоор бид нар хөрөнгө оруулалтын гэрээнд оруулж ирж байгаа. Тэгээд энэ асуудлаа бол Монгол Улсын төр засаг өөрөө нэг мөр цэгцлэх ёстой гэж ингэж үзэж байна аа.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Намайг сайд байх үед болчихсон юм шиг л хариулах шиг боллоо. Наранцогт даргаа. Тэр жагсаалтад орчихсон юм шиг. 2015 онд би сайд байгаагүй шүү дээ тиймээ. Би 2015 онд уу? Харин тийм одоо хүчин төгөлдөр байгаа шүү дээ. Одоо хүчин төгөлдөр байгаа. Тийм учраас цаад компани чинь тэгж байгаа байхгүй юу. Тэгэхээр Учрал сайдын тэр хэлж байгаа бол та чинь сайд шүү дээ. Тийм учраас Засгийн газрын шийдвэрийг та өөрөө хуралдаа оруулна. Тийм учраас нүүрсээ ч гэсэн тэр наад уранаа ч гэсэн тэр шийдвэрлэх боломж нь бол Засгийн газарт бүрэн байна шүү дээ. Тэгэхээр Монгол Улс тийм

улс шүү дээ гээд бид нарт Их Хуралд яриад байдаг нь бол яг сайд хүний үгэнд тийм зохистой сонсогдохгүй байна. Би асуулт асуугаагүй Учрал сайд ойлголоо. Ер нь тэгэхдээ маш дэвшилттэй байгаа, маш дэвшилттэй. Энэ бол энэ гэрээ байгуулагдсанаар дараа дараагийн олон хөрөнгө оруулагч нар бол бас итгэл үнэмшил Монгол Улсад төрнө шүү төрнө.

Гэхдээ Монгол Улс авдаг татвараа авдаг байх ёстой. Янз янзын байдлаар нөлөөлж байгаад болчихдог юм байна гэдэг тийм байдал ерөөсөө хүмүүст итгэл үнэмшил төрүүлж ерөөсөө болохгүй. Татвараа бүгдийг нь л авдаг байх ёстой. Тэр нэмэгдсэн өртгийн албан татвар дээр тэгээд яг тодорхой зүйлийг дараа нь чуулган дээр асууна шүү Наранцогт дарга аа. Тэгээд би нэг юунд оруулчихсан юм шиг хариулт өгөх гээд байгаа юм уу? Тойруулаад байгаа юм уу? Ойлгосонгүй. Баярлалаа амжилт хүсье ээ.

Р.Сэддорж: Баярлалаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг бол дэмжиж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд энэхүү хөрөнгө оруулалтын гэрээ Улсын Их Хурлын тогтоолын төсөл холбогдох хуулийн төслийг өргөн барих үедээ 16 жилийн турш улс төр эдийн засгийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлоор гацаж ирсэн энэ том төслүүдийг хөдөлгөх ийм улс төрийн эр зориг шийдвэр гаргалаа гэдгийгээ онцолж хэлсэн байгаа. Тэгэхээр энийг одоо гацааж байсан хүмүүс тэр хүмүүсийн гар хөлүүд бол энэ танхимд байгаа гэж Ерөнхий сайд хэллээ гэж ингэж ойлгосон.

Тэгэхээр одоо тэр хүмүүсээ нэртэй устай нь мэдэж авмаар байна. Хэн нь нүүрсчин юм, хэн нь алтчин юм гэдэг асуудлыг эзэн биетэй нь хэлэхгүй бол болохгүй байна. Яагаад гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3-д Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно гэж ингэж заасан. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйл Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх гэсэн 8 дугаар зүйлийн 8.1.23-д гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг санал хураалтад оролцохоос татгалзах үүрэгтэй гэж хуульчилсан байгаа. Тийм учраас Засгийн газар болон хуралдаан даргалагчаас энэхүү Ашигт малтмалын хуульд өөрчлөлт орж байгаатай холбоотой нүүрсний стратегийн гэрээг байгуулахтай холбоотой асуудлыг хэлэлцэж байгаатай холбоотойгоор энэ нүүрсчин гишүүд санал хураалтад оролцохоор би сонирхлын зөрчилтэй гэж хэлсэн гишүүн байна уу? Татгалзсан тийм гишүүн байна уу? Би энэ хэлэлцүүлэгт оролцох боломжгүй. Би сонирхлын зөрчилтэй гэж урьдчилж хэлсэн гишүүн байна уу? Тэр бүлэглэл садаа болоод хувийн сонирхлоор янз бүрийн гар хөл болоод байгаа Их Хуралд сонирхлын зөрчил үүсгээд байгаа гишүүдийг нэрлэж өгөөч ээ гэж Засгийн газраас хүсэж байна. Ийм асуулт байна.

Р.Сэддорж: Учрал сайд.

Н.Учрал: Ер нь Энхбаяр гишүүн асуулга тавьсан, асуулгын хариуг бол илгээсэн байгаа. Тэгээд мэдээж одоо хууль хяналтын байгууллагаар эцэслэн тогтоогдоогүй байгаа тохиолдолд хэн нэгэн нэрийг нь дурдах нь мэдээж зохимжгүй. Тэгэхдээ Энхбаяр сайдын асуулгын хариултыг бэлдэх гэж Засгийн газраас хууль хяналтын байгууллагуудаас мэдээллийг авахаар Монгол УЕП, АТГ хууль хяналтын байгууллагууд руу бол

хүсэлтүүдийг нь явуулсан. Ингээд зохих хариуг бол явуулсан. Тэгэхээр мэдээж хууль хяналтын байгууллагаар ийм шалгагдаж байгаа ч юм уу тийм асуудлууд эцэслэн тогтоогдоогүй байгаа тохиолдолд бол бид хэн нэгнийг тийм цоллоод зарлаад байх нь бол зохимжгүй. Гэхдээ мэдээж энэ хөрөнгө оруулалтын гэрээний асуудал дээр ч тэр бусад энэ мега төслүүдтэй холбогдуулаад хэлэлцэж байгаа асуудлууддаа ч тэр хэрвээ хувийн компанитай хамаарал бүхий этгээд нь хувь хувьцаа эзэмшдэг ийм ашиг сонирхол бүхий хүмүүс байвал энэ санал хураалтаас татгалзах ийм бол хуультай.

Тийм учраас бол яах вэ ер нь өнгөрсөн хугацаанд ийм тохиолдлууд зөндөө гарч байсан. Жишээ нь Боловсролын хуулийг хэлэлцэж байхад ч гэсэн би санал хураалтад оролцоогүй. Түүн шиг ер нь бол ашиг сонирхол бүхий янз бүрийн байдлаар хамаарал бүхий этгээдүүд нь ийм бизнес эрхэлдэг тэр байгаа тохиолдолд санал хураалтаас оролцохгүйгээр татгалзаж гаргах ийм хуультай түүнийг ойлгох ёстой.

Тийм учраас цаашдаа бол мэдээж хэн ч хувийн бизнес эрхэлж болно. Гэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөж байвал тухайн санал хураалтад байр сууриа илэрхийлэх, санал хураалтад оролцох ийм шаардлагагүй ээ. Тийм учраас үүнийг ойлгох ёстой. Түүрүүн Ганбаатар гишүүний асуулт дээр би нэмж хэлбэ. Парламент дэмжих ёстой. Одоо энэ мега төслүүдийг явуулж байхад ялангуяа 2015 онд угаасан нүүрсийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзсэн энэ шийдвэр одоо хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа.

Тийм учраас хөрөнгө оруулагч талаас та нар угаасан нүүрсийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзээд НӨАТ-аас чөлөөлдөг. Тийм бол дэлхийн тавхан орон дараагийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн биш ээ гэж үзэж байвал бусдад адилхан хандаарай гэдэг ийм л байр суурийг илэрхийлж байгаа юм. Тийм учраас Засгийн газар холбогдох саналуудыг аваад энэ асуудлыг шийдвэрлэнэ ээ. Тэгээд Ганбаатар гишүүнд дахиж хэлэхэд энэ асуудлыг Засгийн газрын зүгээс шийдвэрлэнэ ээ.

Уул уурхайн яам ч гэсэн саналаа аваад энэ ажлыг эхлүүлж байгаа. Тэгээд энэ асуудал шийдэгдвэл бүгдэд нь ялгаагүй тэгшхэн.

Р.Сэддорж: Баярлалаа.

Ганц асуулт байна. АМНАТ-ийн хувийг нэмж байгаа. Тэгэхээр тухайн уурхай байгаа аймаг, суманд нийт татвар, хураамж хэдэн хувиар нэмэгдэх вэ гэдэг асуулт байна.

Энхбаяр гишүүний асуултад одоогоор ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн гишүүд мэдээлэл ирээгүй байна аа.

Учрал сайд.

Н.Учрал: Одоо яг энэ Баялгийн сангийн хуулийн дараа бид нар нөгөө АМНАТ-аар орлуулах төрийн эзэмшлийн 10 хувь хэмжээгээр 34 хувийг орлуулах тогтоолыг хэлэлцэнэ. Одоо бид нар Баялгийн сангийн хуулийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр Байнгын хорооны даргын асуултад хариулахад тусгай АМНАТ-ийн босго бол яг энэ 34-ийг орлуулах дээр таваараа байгаа. 13 н төрлийн төлбөр, татвар хураамжуудыг яг санхүүгийн схем дээрээ тавиад 50 дээр нэмэх 1 болгоод үр өгөөжийг тохируулахыг хийсэн ашгийг. Тэрнээс биш нөгөө орон нутгийн хөгжлийн сан руу үндэсний баялгийн сангаас чинь орон нутгийн хөгжлийн сан руу хуримтлагддаг хэсэг энэ тэр яг хэвээрээ байгаа гэсэн үг. Өсөн нэмэгдэх АМНАТ бол тусдаа ойлголт. Тэрийг Цөмийн энергийн хуулиар бид нар жагсаалтыг

баталсан. Нөгөө нэг фунтийн үнэ нь 50-аас 60 бол нэг ч гэдэг юм уу, 60-аас 70 бол 2 хувь ч гэдэг юм уу ингээд 9 хүртэл нэмэгдүүлнэ.

Тэгэхээр зах зээлийн ханш хэрхэн өссөнөөс шалтгаалаад Цөмийн энергийн хуулийг эшлээд тэр нь бол Монгол Улсад өгөөж болж ирнэ ээ. Тэрнээс биш тусгай АМНАТ бол 5 хувиар хэвээрээ байгаа гэсэн үг. Орон нутаг руу орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлдгээрээ төвлөрүүлнэ. Тэр түрүүний тэр Дорноговь аймгийн Улаанбадрах суманд бол өнгөрсөн 4 жилийн хугацаанд 1 тэрбум төгрөгийг жил болгон төлөөд ирсэн. Цаашдаа бүтээн байгуулалтын үе буюу уурхай ашиглаж эхлэх хүртэл бол энэ тэрбум төгрөг төлөгдөөд явна. Уурхай ашиглаж эхлэх буюу 2027 оныг дуусаад 2028 оноос уурхай ашиглаж эхлэх үеэс 1 сая долларыг Улаанбадрах суманд жил болгон төлнө. Үүнийг ямар зориулалтаар ашиглах вэ гэдгийг аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хамтын зөвлөлөөрөө оруулаад сургууль цэцэрлэг барих юм уу нийгмийн дэд бүтэц хөгжүүлэх юм уу гэдгээ зөвлөлөөрөө оруулаад төлөвлөгөөгөө батлаад шийдвэрлээд явна гэдгийг хэлье ээ.

Р.Сэддорж: Баярлалаа. Энхбаяр гишүүн тодруулах уу? Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ асуудлыг Улсын Их Хурлын миний асуусан асуултыг чуулганы нэгдсэн хуралдаанаас би протоколдуулж байяа аа. Албан ёсоор протоколд Их Хурлын гишүүдэд хууль сануулахыг хүсэж байна хуралдаан даргалагчаас. Тэгэхгүй бол нүүрсний хэрэгт яллагдагчаар татагдаж байсан гэж мэдээлэл гарч байсан хүн энэ Байнгын хороог даргалаад сууж байна. Хэрэг хэрэгсэхгүй болсон юм уу, болоогүй юм уу, яллагдагч хэвээрээ байгаа юм уу байхгүй болчихсон юм уу мэдэхгүй. Сонсгол дээр бол яригдаж байсан. Стратегийн орд гэж тооцогдож байгаа ордод хувь эзэмшиж байгаа Улсын Их Хурлын гишүүн байгаа, манай танхимд. Тэгэхээр чинь энэ сонирхлын зөрчилтэй асуудлууд байгаад байгаа байхгүй юу.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Хуулийн нэг төслийг ер нь дэмжиж байгаа. Тэгэхдээ тооцоолол дээр та бүхний өгсөн тооцоолол дээр харахад бол асуудал байна уу даа гэж хараад байгаа юм. Яагаад гэхээр хөрөнгө оруулагчид ноогдож байгаа ногдол ашиг бол ер нь ирэх төслийн хугацаанд нийтдээ 5 тэрбум доллар байна гэж байгаа байхгүй юу 90 хувьтай. Хэрвээ тэрүүгээр нь тооцож үзэх юм бол бид нар 34 хувиараа байсан би АМНАТ-ийн тооцооллыг яах вэ нарийн мэдэхгүй учраас тооцсонгүй. Зүгээр ойролцоогоор тооцоход бид нар 7.2 тэрбум доллар олох боломжоо алдаж байгаа юм биш үү л гэж харж байгаа байхгүй юу. Тийм учраас би тооцоолол дээр нэлээн нарийн суух ёстой байх гэж бодож байна аа.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт эхэлье. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт.

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Батчимэг гишүүн, Ганбаатар гишүүн нарын төхөөрөмж ажиллаагүй байна. Дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд сая өмнөх танилцуулгыг Гашуун сухайт-Ганц модыг Батчимэг гишүүн, Батнайрамдал гишүүн 2 ярьсан байх. Батчимэг гишүүн өмнөх төслийг танилцуулна. Батнайрамдал гишүүн энэ төслийг танилцуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.45 цагт

Дараагийн асуудалдаа оръё. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэллээ.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох нь зөвхөн Монгол Улсын төдийгүй хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа эрхэм зорилт юм аа.

Энэхүү зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогод нэгдэж цөмийн эрчим хүчийг ногоон буюу тогтвортой цэвэр эх үүсвэр хэмээн зарлаж байна аа. Дэлхийн зах зээлд цөмийн түлш ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 32 улс 440 цөмийн реактор ашиглаж байгаа бол шинээр барьж байгаа 63 барихаар төлөвлөсөн 88, ирээдүйд төлөвлөж байгаа 344 реактор байна аа. Олон улсын атомын энергийн агентлагаас ураны эрэлд 2024 онд 93 мянган тонн байгаа 2050 он гэхэд 177 мянган тонн болж нэмэгдэх тооцооллыг гаргажээ. Өнөөдрийн байдлаар Монгол Улс 192.2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж нөөцийн хэм хэмжээгээрээ дэлхийд 10-д жагсаж байна аа.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Алсын хараа 2050-д нэмүү өртөг шингэсэн уур уурхайн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилтуудыг тусгаж улмаар Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зөөвч овоо, Дулаан уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 104 мега төслийн нэг болгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын цацраг идэвхт ашигт малтмалын эрэл хайгуулыг эрчимжүүлж, олборлолт, ашиглалтыг олон улсын жишиг стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх нь

экспортын орлого нэмэгдэж эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагаа түншлэлд чухал ач холбогдолтой юм аа.

Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Цөмийн энергийн тухай хууль болон дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтөөр Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орона Майнинг компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протоколд талууд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан. Зөвч овоо төслийг хэрэгжүүлэх хугацаанд Бадрах Энержи ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааны ноогдол ашигт 2.1 тэрбум доллар, АМНАТ-т 717 сая доллар буюу нийт улс орон нутгийн төсөвт 5.6 тэрбум ам.доллар төвлөрөх тооцоолол гарсан.

Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа 5 хувийн тусгай АМНАТ-аар орлуулж 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ тооцоход давуу эрхийн хувьцаа нь 593 сая ам.доллар-ын ноогдол ашиг АМНАТ-т 2 тэрбум доллар үүнээс суурь АМНАТ-д 717 сая доллар, тусгай АМНАТ-д 717 сая доллар доллар, өсөн нэмэгдэх АМНАТ-д 573 сая доллар, нийт улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум долларыг ямар нэгэн эрсдэлгүйгээр төвлөрүүлэхээр тооцож байна. Хэдийгээр 34 хувийн энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч Засгийн газар 34 хувийн хувьцаа эзэмших нөхцөлд төсөл хэрэгжүүлэх үед хөрөнгө оруулагч зардлыг удирдах төслийг зээлээр санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татварын хураамжийг бууруулах боломжтой байдаг тул Засгийн газар анх тооцож байсан ноогдол ашгаа хүртэж чадахгүй байх. Төслийн өгөөж тодорхойгүй хугацаагаар хойшлох эрсдэл үүсэж болзошгүй байна аа.

Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдийг хэрэгжүүлэхдээ жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохоос зайлсхийж төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ эс үгүй бол АМНАТ-өөр оролцох зөвлөмжийг бий болгосон байгааг мөн харгалзах нь зүйтэй. Түүнчлэн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр хураамжийн орлого, ноогдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлт сул мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог бөгөөд хэрэв Засгийн газар 34 хувийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ноогдох нийт 5.6 ам.долларын 1 тэрбум ам.долларын орлогын 82 хувь нь зардлын өсөлтөд өртөмтгий буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18 хувь нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй найдвартай орлогод тооцогдохоор байна. Харин Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг 18 хувиас 45 хувь хүртэл нэмэгдүүлэх боломж бүрдэж байгаа юм аа.

Иймд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөө орлуулж Монгол Улсын Засгийн газар ноогдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн төслийн үр өгөөжийг шууд хүртэх боломжийг бүрдүүлэх зорилгоор уг Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна. Засгийн газар 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг эзэмшсэнээр бусад энгийн хувьцаа эзэмшигчдээс

тэргүүн ээлжид ноогдол ашиг хүртэх хувьцаанд ноогдох хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байх, бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авах. Түүнчлэн компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах зэрэг компанийн тодорхой чухал шийдвэрүүдэд хориг тавих онцгой эрхтэй байхаар талууд харилцан тохиролцоод байна аа.

Түүнчлэн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээг талуудын хооронд байгуулсан протоколыг үндэслэн ураны хүдрийн баяжмалын зах зээлийн үнийг харгалзан 5 хувь хүртэл байхаар тогтоолын төсөлд тусгалаа.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн ТЭЗҮ-д тулгуурлан олон улсын фаст стандартын дагуу санхүүгийн тооцооллын загварыг Монголын тал боловсруулж хөрөнгө оруулагчтай тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх нөхцөлийг баталгаажууллаа. Хэрэв Монголын талын шууд үр өгөөж 51 хувьд хүрэхгүй байх тохиолдолд талууд үр өгөөжийг 51 хувьд хүргэх шаардлагатай үр өгөөжийн тохируулга хийх, хөрөнгө оруулагч нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар тохиролцоод байна аа.

Түүнчлэн хөрөнгө оруулагч талаас нийт 27 төрлийн татварыг тогтворжуулах саналыг ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулж зөвхөн ААНОАТ нэмэгдсэн өртгийн албан татвар, АМНАТ, гаалийн тариф, гаалийн тариф, гаалийн татвар гэсэн 4 төрлийн татварыг тогтворжуулах. Харин Байгаль орчны салбарын албан татварыг тогтворжуулахгүй байхаар тохиролцлоо. АМНАТ-ыг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулга инфляц тооцохгүйгээр бүрэн төлөхөөр тусгалаа.

Хөрөнгө оруулалтын гэрээг төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж байгаа 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд авч үзэх ба бусад ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлүүдийг хамруулахгүй байх, олборлолт үйлдвэрлэлийг газар доор уусган олборлох технологиор явуулах, ТЭЗҮ Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан төслийн бүх үе шатанд Байгаль орчны мониторинг, гео экологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаа болон технологид олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр 3 жил тутамд хөндлөнгийн аудит хийлгэх талаар хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохиролцлоо. Мөн төсөл хэрэгжүүлэгч компани нь Дорноговь аймгийн Засаг дарга төсөл хэрэгжих Улаанбаатар сумын Засаг даргатай 3 талт хамтын ажиллагааны гэрээ байгуулж орон нутгийн хөгжлийг дэмжих хүрээнд жил бүр 1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийхээр, төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90-ээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байх, уурхайн ашиглалтын үе шатад нийт туслан гүйцэтгэгчдийн 60 хувиас доошгүй, жилийн нийт худалдан авалтын үнийн дүнгийн 40 хувиас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч хуулийн этгээд байхаар тус тус тохиролцлоо.

Тус тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.11-д заасан Зөвч овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ ээ гэж үзэж байна аа.

Уг асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.3-д заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэх тул Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай горимоор хэлэлцэхээр өргөн мэдүүлсэн юм аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя.

Санжаагийн Наранцогт. Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Амарсанаагийн Алтанхундага Мон-Атом компанийн ахлах геологич, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лувсаншаравын Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга, Шаравдоржийн Ганхуяг АМГТГ-ын дарга, Батболдын Мөнхтөр Үндэсний геологийн албаны дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын дарга, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Геологи уур уурхайн БХЗГ-ын ахлах шинжээч, Цэдэнбалжирын Төгсбуян Эрдэс монгол компанийн Геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Сүхбатын Халиунаа Мон-Атом компанийн Геологи уурхайн албаны дарга, Лхагвын Өнөрбаатар Эрдэнэс Оюу Толгой компанийн Геологи уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Салангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ганболдын Энхмөнх Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны газрын дарга, Зинамядарын Батбаяр Усны газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал, Чулуунбатын Нандин-Эрдэнэ Дорноговь аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Түмэнжаргалын Төрбадрах Эрдэнэс Монгол компанийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Бямбаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал амьтны эрүүл мэндийн газрын дарга, Лхагваагийн Баттөр ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Далайжаргал Мон-Атом компанийн захирал, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Алтангэрэлийн Мандуул ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн газрын дарга, Балдоржийн Баатарцогт Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Дашдагвын Сугарсүрэн Мон-Атом компанийн захиргааны албаны дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Чойжанцангийн Нарантуяа ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ гадаад хамтын ажиллагааны газрын дарга, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компани, Сүхдоржийн Батхүлэг дотоод хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Дашдоржийн Баярхүү олон улсын харилцааны судлаач, профессор.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Мандхай гишүүнээр нэрсийг тасалж байна. Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Би түрүүн нөгөө ярьсан болохоор энэ дээр зүгээр яагаад ийм тооцоолол хийсэн юм бэ гэдэг дээрээ нэг хэлчихье гэж бодсон юм аа. Францын талын хөрөнгө оруулалтын төслийн хугацаанд авах ногдол ашиг бол 5 тэрбум доллар юм байна тэрний 90 хувь байгаад байгаа байхгүй юу. Тэгэх юм бол одоо хэрвээ бид нар 34 хувиа эзэмшиж байсан бол 5.6 тэрбум долларын 34 хувь буюу нэг ойролцоогоор тэрбум 900 сая долларыг Монгол Улсад ногдол ашгаар авах байжээ. Бид нар одоо 10 хувьтай давуу эрхтэй 10 хувьтай болсноороо 560 сая долларыг ноогдол ашгаар авна. Тэр нь болохоор Монгол Улсад орж ирж байгаа өгөөжөөс 5.9 тэрбумаас 560-ыг хасахаар 5,3 тэрбум болж байгаа юм. АМНАТ-ийн тооцооллуудыг би нарийн хараагүй учраас ойролцоогоор та бүхний ярьж байгаагаас ингээд 1 тэрбум 700 саяыг хасаж байгаа юм аа. Тэгээд 1 тэрбум 900-гаа нэмэхээр ойролцоогоор 5.6 тэрбум доллар Монгол Улсад орж ирэх нь ээ гэж байхгүй юу. Тэгээд энэ төслийн аль ч хөрөнгө оруулалтын тохиолдолд болохоор тухайн компани ашигтай ажиллаж л байгаа хөрөнгө оруулалтаа хийгээд л явна. Тэгэхээр тэрбум 600 сая долларын хөрөнгө оруулалт гээд байгаагийн чинь 500 сая нь үйлдвэр ашиглалтад орох хүртэл хугацааных байгаад байгаа байхгүй юу. Тэгээд би зүгээр бодохоор зүгээр яг 34 хувиараа бараг байж байгаад зээлээ өөрөө өр төлбөр дээрээ бүртгэж авч байгаад яг 2500 тонныг жил болгон борлуулаад ирэхэд Монгол Улс 34 хувийнхаа ашгаар хангалттай нөхчихөөр л юм шиг л харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тооцоолол дээр би асуудал байна гээд энэ дээр л гол асуугаад байгаа асуулт байгаа.

Р.Сэддорж: Учрал сайд хариулъя 3 номер.

Н.Учрал: Соронзонболд гишүүн санхүүгийн хүн учраас асууж байх шиг байна. Их Хуралд өмнө нь Цөмийн энергийн хуулийг хэлэлцэж байхад гишүүд ер нь санал хэлж байсан. Ер нь тодорхой чиглэлүүдийг өгсөн. Юу вэ гэхээр би жишээ нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг их муу гэрээ болчихсон гэж би хэзээ ч хэлэхгүй. Мэдээж Монголын эдийн засгийг өсгөж тэлэхэд хувь нэмрээ оруулсан. Гэхдээ бид нар тэр гэрээний сургамж авах ёстой энэ олон жилийн дараа. Оюу Толгойн гэрээг хэлэлцэж байх үед ярилцаж байсан хэлэлцэж байсан тэр протоколуудтай танилцсан. Тухайн үед энэ Оюу Толгой төсөл Монгол Улсад ноогдох үр ашиг буюу 34 хувийнхаа ашгийг аваад 6.2 тэрбум долларыг Монгол Улсад хуримтлуулна үр өгөөж нь ийм байна гэж байсан юм байна лээ 34 хувь яг өнөөдрийн бид нарын өөдрөг төсөөлөл шиг. 2023 оны байдлаар бодит гүйцэтгэл хэд байгаа гээч Оюу Толгой 2.8 байгаа шүү дээ. Их гоё юм ярьж байсан байхгүй юу тухайн үед. Тухайн үедээ ч гэсэн хүн болгон л мэдээж Монгол Улсад ноогдол ашгаа үр өгөөжөө хүртээнэ ээ гээд мэдээж энэ чинь төсөөлөөд л ингэж зардал нь ийм өндөр болоод ийм ийм асуудал үүснэ ээ гэдгийг төдийлөн нөгөө эрсдэлийг бүрэн тооцож чадаагүй л байхгүй юу. Тэрнээс биш тухайн үед ажиллаж байсан хүн болгон л энэ гэрээг Монгол Улсад ашигтай хийхээр ингээд л ярилцаад л 6.2 гээд л Өнөөдөр 2.8.

Гэтэл өнөөдөр Зөөвч овоо төслөөс Монголын талд ноогдох орлого дээр бид нар бодож үзсэн 5.6 тэрбум доллар 34 хувиар олох бололцоотой. Гэхдээ эрсдэлгүйгээр. Энэ тохиолдолд бол эрсдэл нь маш өндөр байгаа байхгүй юу. Эрсдэл нь тэгэхээр ер нь ноогдол ашиг гэдэг хамгийн эрсдэлтэй орлого. Та тэрийг мэдэж байгаа. Хамгийн эрсдэлтэй юу вэ гэхээр тэр чинь татвараа төлөөд төлбөрөө төлөөд бүх зардлаа хасаад хамгийн сүүлд ирж байгаа юм. Ноогдол ашиг байхгүй юу. Гэтэл өнөөдөр манай энэ төрийн өмчит уул уурхайн компаниуд ч бай төрийн өмчийн компаниуд ч бай нөгөө зардал өсгөөд ашиг нь өсдөггүй. Нөгөө зардал нь өсгөөд байдаг нэг ийм аргатай болчихоод байна шүү дээ. Тэрэн шиг ийм төсөл дээр ч гэсэн бид нар хамгийн зөв хувилбар нь өөрөө юу юм бэ гэхээр шууд тэдний ашигтай ашиггүй ажиллана уу гаднаас зээлээ авна уу тэр төслийг яаж удирдахаас үл хамаараад Монгол Улс манай газрын хэвлийн баялгийг ашиглаж байгаа бол бид нар ямар ч яриа хэлцэл байхгүйгээр шууд борлуулалтаас нь АМНАТ-аа авъя гээд байгаа байхгүй юу.

Тэд ямар байхаас үл хамаарна. Ингэх юм эрсдэл багасна. Тэгэхээр эрсдэл энэ чинь 45 хувийн эрсдэл багасаж байгаа байхгүй юу энэ тооцоолол. Энийг бид нар нэг тийм одоо таамгаар яриад байгаа зүйл бол огт биш. Монгол Улс анх удаа өөрөө гаднын компанитай гэрээгээ хийхдээ өөрийнхөө хөрөнгө оруулалтын гэрээний драфтыг боловсруулаад өөрсдийнхөө хөрөнгө оруулалтын гэрээний драфт дээр ажиллаж байгаа юм.

Хоёрт бид анх удаа Үндсэн хуулийн өөрчлөлт дээр тохируулаад санхүүгийн схем хийсэн. Энийг тэр фаст гэдэг стандартын дагуу тэр ай эм эмээс гаргадаг аргачлалын дагуу анх удаа өгөөж тохируулаад яг одоо та мэдээж санхүүгийн хүн сая ингээд манай энэ ажлын хэсгийнхэн дэлгэрэнгүй танилцуулах байх. Ингээд бүх хувилбарууд дээр тэр ассампшнуудыг гаргаад ингээд тооцож байгаа тоогоор ярьж байгаа. Ингээд бид нар тулгаж байгаа байхгүй юу 50 дээр нэмэх 1 нь ээ хүрэхгүй байна гээд хөрөнгө оруулагч талд. Яагаад хүрэхгүй байгаа юм бэ? Бид ямар ч тохиолдолд нэг л зарчим барина. Бид санхүүгийн хариуцлага хүлээхгүй бид хөрөнгө оруулалт хийхгүй, яагаад гэвэл бид нар газрын хэвлийн баялгаа ашиглуулж байна. Энэ тохиолдолд бид заавал 50 дээр нэмэх 1-ээ авна л гэдэг. Ямар ч тохиолдолд. Тэрнээс биш компанийн менежментэд ордог, нэр зүүдэг, тэгээд баахан захирал тавьсан болдог тэгээд ашгаа хүлээгээд суудаг. Тэгээд хүлээсээр байтал одоо өнөөдрийг хүртэл бид нар өмнөх гэрээнийхээ ноогдол ашгийг хүртэж чадахгүй байна шүү дээ.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Би бараг асуух гэж байсан асуултуудыг Учрал сайд бараг хариулчихлаа даа. Тэгээд яах вэ зүгээр төслийг бүрэн дэмжиж байна тэгээд энэ маш олон зүйл дээр жишиг болж байгаа гэдэг зүйлийг иргэд олон нийт маань сайн ойлгоосой. Учрал сайд бас хариултууд ч дээр ч, танилцуулга дээрээ ч хэллээ. Татвар, санхүүгийн чиглэлээр, олборлолт технологийн чиглэлээр, Байгаль орчны чиглэлээр гээд маш олон ойлгомжтой мэдээллүүдээ өгчихсөн. Би зүгээр яах вэ энэ дээрээс илүү бүс нутаг орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр бас ямархуу хамтын ажиллагаа хөрөнгө оруулалтууд байгаа гэдэг зүйлийг ойлгуулаасай. Энэ уул уурхай, хариуцлагатай уул уурхайг дэмжиж байж улс болон орон нутаг ч гэсэн хөгжих бололцоотой гэдэг зүйлийг ойлгож иргэд маань хүлээж яваасай гэж хүсэж байгаа юм. Энэ дээр бас орон нутгаасаа гадна энэ бизнес эрхлэгчдийг буюу дотоодын ААН байгууллагуудыг хүртэл худалдан авах ажиллагаагаар дэмжих ийм гол гол чухал зарчмууд байна. Тэгээд энэ төслүүдийн мэдээллийг олон нийтдээ маш ил тодоор явж байгаад энэ чиглэлдээ манай бизнес эрхлэгч нар бодох ёстой.

Наад захын нэг бошик үйлдвэрлэдэг компани Монголд бий болох ёстой байхгүй юу наад зах нь. Тэгэхээр энэ зүйлүүд рүү бас илүү их үр өгөөж болон төслийн ач холбогдол үнэхээр байгаа шүү гэдэг зүйлийг би хэлмээр байна. Тэгээд би сая энэ Төсвийн хууль батлагдахад Засгийн газарт чиглэл өгөх тогтоол дээр нэг санал гаргасан юм аа. Энийг бас ЗГХЭГ-ын дарга аль сайдад хуваарилж байгаа юм анхаарч өгөөч ээ гэж байгаа юм. Таны хэлсэн үгэнд ч дурдлаа. Цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг цаашдаа илүү их ашиглах чиг хандлага руу явлаа дэлхий нийтээрээ. Энэ чиглэлдээ бас хөрөнгө босгох, хөрөнгө олдох магадлал байна аа.

Тийм учраас би энэ цэвэр эрчим хүчний эх үүсвэрт орж байгаа энэ АЦС-ыг барьж байгуулах асуудлын суурь нөхцөл судалгаанаасаа гадна энэ чиглэлийн хууль эрх зүйн орчноо буюу ашиглах чиглэлийнхээ хууль эрх зүйн орчноо одооноос бодож орчноо бүрдүүлмээр байна аа.

Тийм учраас цэвэр эрчим хүчийг дэмжих ногоон эдийн засгийг дэмжих ийм нэг тодорхой төрийн бодлого хуультай болгож зохицуулж өгөөч ээ гэдэг зүйлийг тавиад байгаа юм.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээ холбогдох хуулиудаас гадна энэ чиглэлдээ бас нэгэнт та энэ чиглэлийн хөрөнгө оруулалтуудыг авч явж байгаа учраас холбогдох яамдуудтайгаа Эдийн засгийн хөгжлийн яам энэ тэртэй ярихад дараа дараагийн цэвэр эрчим хүчний гэдэг юм уу ногоон эдийн засгийг дэмжих бодлогыг энэ оруулж ирж байгаа хөрөнгө оруулалтын гэрээтэй адил байдлаар дэмжиж өгөөч ээ. Иргэд олон нийтэд ойлгуулж өгөөч ээ. Энийг бид эртнээс ярихгүй бол манай МАА ч гэсэн энэ хүлэмжийн хийн ялгаруулалтын нөхцөл байдалд хавчигдах гээд байгаа юм. Одоо ерөөсөө ХАА-н салбарт зээл олдохгүй байна шүү дээ. Яагаад гэхээр ХАА-н салбар хамгийн их хүлэмжийн хий ялгаруулдаг салбар гээд дэлхий нийтээрээ ярьж байна. Сүүний үнээ жишээ нь жилд хэчнээн одоо килограмм хүлэмжийн хий ялгаруулж байна гэдэг тооцоо гаргаж ирээд түрүүчийн улсууд МАА дээр буюу жишээ нь үхэр дээрээ татвар тавиад эхэлж байгаа байхгүй юу. Энэ удахгүй тэгээд манайх нөгөө энэ МАА ч гэдэг юм уу бусад бүтээгдэхүүнээ экспортод гаргана.

Р.Сэддорж: Хариулт Учрал сайд 3 номер.

Н.Учрал: Тийм Сайнзориг гишүүн их зөв асуудлыг хөндөж байгаа юм аа. Ер нь бид нар нөгөө олон улсад хүлээсэн үүрэг дэлхийн хөгжлийн чиг хандлагаас нэг учиргүй урд нь гарахгүй юмаа гэхэд нэг хоцрохгүй явмаар байх юм. Тийм учраас нэг ийм жоохон дэвшилтэт үзэл санаа руу явмаар байна л даа. Тэгээд энэ Оюун-Эрдэнийн Засгийн газар бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр энэ 14 мега төсөл гээд байгаа зүйл чинь ерөөсөө л нэг зориг гаргаад энэ олон жил хугацаанд шийдэж чадаагүй зүйлүүдийг шийдчихье ээ л гэж байгаа шүү дээ. Тэгээд 10 пост хийхээр л айгаад зугтчихдаг бид нар байж болохгүй л дээ. Тийм учраас нэг дэвшилтэт үзэл санааныхаа төлөө хамт явах ёстой. Тийм учраас энэ 14 мега төсөл гээд байгаа чинь энэ ирээдүй хойчийнхоо төлөө бас дэвшил гаргая л гэж ингэж зорьж байгаагийн л зорилт болохоос биш зарим энэ бүлэг эрх ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа хүмүүст таалагдахгүй шүү дээ. Энэ төслүүд чинь таалагдахгүй. Тэгээд энэ төслүүд явлаа гээд яг өнөөдөр нэг их ард түмэн уухайлаад дэмжээд нэг тийм од мод болохгүй. Зүгээр хувь улс төрчийн хувьд бол энэ тийм хүсээд байх сэдвүүд биш байхгүй юу. Гэхдээ энэ Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед эхлүүлсэн энэ олон жил гацсан ажлууд явснаараа ирээдүй цаг бол энэ Оюун-Эрдэнийн Засгийн газарт би баярлах байх гэж бодож байгаа юм. Алийн болгон бид нар чинь нэг ийм нэг жалга довны юм яриад явах вэ дээ. Дэлхий нийт өөрчлөгдөж байна, ногоон шилжилт рүү явчихлаа. Хүний нөөц өөрчлөгдөж байна. Энэ хиймэл оюун ухаан чинь амьдралын хэв маягийг өөрчилж байна шүү дээ. Бид нар хоцрохгүй байх ёстой шүү дээ. 27 жил уран, уран гээд ярилаа. Гэтэл нөгөө Казахстан дэлхийд нэгд орчихлоо шүү дээ. 27 жил улс төржлөө. 27 жил төлөөлөгчийн газраа байгууллаа шүү дээ. Тэгээд би чуулган дээр хэлсэн. Нэг хүн төрөөд Их Хурлын гишүүн болчихсон байхад би төлөөлөгчийн газар байгуулагдсаар ярьсаар л.

Одоо буцаад Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний алдаа оноо гэхээсээ илүү тэр төсөл явснаараа энэ эдийн засаг тэлсэн үү гэвэл тэлсэн. Гэхдээ энэ удаагийн хөрөнгө оруулалтын гэрээ нэг онцлог байхгүй юу. Бид нар сургамжаа эргэж харах ёстой, сургамж авах ёстой. Бид 2019 онд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад газрын хэвлийн баялгийнхаа 50 дээр нэмэх нь ард түмэнд өгнө өө гэгчхсэн. Бүүр ийм хэмжүүр тавиад өгчихсөн. Тийм учраас энэ ажлын хэсэг дээр олон улсын зөвлөх үйлчилгээний компаниуд ажилласан. Орчин цагт боловсрол эзэмшсэн мэргэжлийн санхүүч нар ажилласан. Бид нар энэ орчин цагт боловсрол эзэмшсэн энэ санхүүч нарынхаа моделийг харж асуудалд шинжлэх ухаанчаар нэг гэрээ хийж үзье л дээ гэж л би зорьсон.

Тэрнээс биш нөгөө түрүүн яриад байсан энэ нөгөө стратегийн ач холбогдол бүхий энэ төрийн эзэмшлийн ордуудын эзэмшиж байгаа компаниудын 34 хувийг шууд авна энэ тэр гэдгээс илүү энэ чинь вин вин л байх ёстой шүү дээ. Хөрөнгө оруулагч тал хожих ёстой. Засгийн газар ард түмэн хожих ёстой. Тэгэхдээ энийг баримжаагаар биш ингээд санхүүгийн схем дээр нь олон улсын стандартын дагуу тавьж байгаад нэг эрүүл саруулаар асуудалд ханддаг болох ёстой л гэж зорьж байгаа. Тэрнээс биш мэргэжлийн баг ажилласан. Энд 5 салбарын сайд нар дэд ажлын хэсгүүдээ ахалсан. Мэргэжлийн шинжээч нар ажилласан, экспертүүд ажилласан, тэгээд эд зөвлөж байгаа.

Тэрнээс биш миний хувьд ажлын хэсгийн ахлагчийн хувиар бол янз бүрийн бүх мэргэжлийн салбарыг мэддэг гэж ярихгүй. Надад бол гол нь ашиг сонирхлын зөрчил байхгүй. Би энэ аливаа энэ уул уурхайн салбарын асуудал дээр ийм нэг ийм дүлий цэрэг шиг хандаж байгаа шүү дээ. Яагаад гэвэл надад ямар нэгэн нүүрс ч байна уу, энэ уул уурхайн салбарын нэг ч ашиг сонирхол байхгүй байхгүй юу даа. Тийм учраас мэргэжлийн хүмүүсийн үгийг сонсоод эрүүлээр ирээдүй хойчийнхоо төлөө энэ Сайнаа гишүүн шиг орчин үеийн юм ярья аа.

Р.Сэддорж: Мандхай гишүүн.

М.Мандхай: Миний хувьд энэ төслийг дэмжиж байгаа. Яагаад гэхлээр үндсэндээ Оюу Толгой гэдэг компани сайн муу гэрээ гэж ярихаасаа илүүтэй өнөөдөр 24 мянган хүнийг ажилтай, орлоготой, түүнийгээ дагаад гэр бүлийг нь амьжиргааг нь залгуулаад олон хүн эндээс хөгжөөд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ зэргийн ийм мега төслүүд хэрэгжих нь маш зүйтэй гэж бодож байгаа. Гэхдээ яах вэ зүгээр энд бас нэг юм асуумаар байна л даа. Байгаль орчин манайх ингээд нарийвчилсан байгаль орчны үнэлгээ хийгддэг. Энэ төслийг энэ гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор урьдчилсан байдлаар нийгэм, эдийн засгийн үнэлгээ ер нь хийгдсэн үү гэж би асуумаар байгаа юм. Яагаад гэхлээр энэ төслийг хэрэгжүүлэхэд маш их хэмжээний шилжилт хөдөлгөөн бий болно. Ажиллах хүч тийшээгээ нүүх юм байна. Гэрээн дээр ялангуяа гэр бүлээрээ шилжилт хөдөлгөөнийг хийнэ ээ гээд оруулчихсан байгаа юм байна. Тэгэхээр энэ өөрөө нийгэм эдийн засгийн үнэлгээ хийгдээд тэнд оршин суухдаа хаана оршин суух юм. Одоо байгаа уугуул иргэдтэй нь ямар сөрөг импактууд үзүүлэх вэ. Энэтэй холбоотой нарийвчилсан судалгаа хийгдсэн юм болов уу гэдгийг асуумаар байна. Бид нар нөгөө аливаа төслийг эхлүүлэхдээ одоо байгаа орон нутгийн нийгмийн асуудалд нь сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр энэ мега төслүүдийг хэрэгжүүлэх ёстой байгаа учраас эндээс асуумаар байна.

Хоёрдугаарт ер нь бол бид нар чинь говийн бүсийн хөгжилд энэ төсөл хэрхэн уялдах вэ гэдгийг асуух нь зүйтэй байх. Орон нутгийн бизнес энэ иргэдийн оролцоог ер нь яаж харж байгаа вэ? Тийм учраас би энэ нийгэм, эдийн засгийн үнэлгээнд тусгагдсан байгаа юу хэрхэн хийж ажиллах гэж байна? Тэгээд орон нутгийн энэ чанарыг сайжруулах боловсрол, эрүүл мэнд, соёл гээд энэ олон асуудлуудыг хэрхэн энэ төлөвлөгөөтэй шат дараалалтайгаар хөгжүүлнэ гэж харж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Р.Сэддорж: Ажлын хэсэг. Ажлын хэсгийнхэн хоорондоо ярих юм байвал гараад ярьчих даа. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяагаар ахлуулсан дэд ажлын хэсэг ажилласан. Тэгээд би энэ дэд ажлын хэсгийнхэнд сэтгэл хангалуун байгаа. 27 төрлийн татварыг тогтворжуулна гээд хөрөнгө оруулагч талын тавьсан санал дээр үгүй гэж байр сууриа илэрхийлж, нотлох баримтууд, судалгаагаа сайн

харуулж салбарынхаа нөхцөл байдлыг сайн тулгасны үндсэн дээр Байгаль орчныг тогтворжуулаагүй. Нэг ёсондоо тухайн үеийн хууль эрх зүйн орчноороо шийдэгдээд явна.

Дээрээс нь ус бохирдуулсан, агаар бохирдуулсан бол энэ төлбөр авах ёстой. Энэ төлбөрийг Засгийн газрын үр өгөөж тооцоогүй. Энэ бол ус бохирдуулсан бол эргээд тэр нөхөн сэргээх ажилд нь тэр мөнгийг зарцуулдаг болохоос энэ Засгийн газрын үр өгөөж биш байхгүй юу гэдэг зүйлийг хэлэх гэж байгаа юм. Тэр ажлын байрыг нэмэгдүүлэхийг асуусан уу? Орон нутгийн хөгжилд яаж хувь нэмэр оруулах вэ гээд асуусан уу? Би ажлын байрыг нэмэгдүүлэх дээр орон нутгийн хөгжлийг дэмжих дээр нэг зүйлийг харин түрүүн би байгаль орчин дээр хэлж байна шүү дээ. Байгаль орчны үнэлгээн дээр бол нэгд тэр тогтворжуулахыг хийгээгүй, тогтворжуулаагүй.

Хоёрт усны нөөц горимын чанарын төлөв байдал, байнгын ажиглалт, хяналт шинжилгээ хийсэн. Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. ТЭЗҮ дээр Байгаль орчны мониторинг, гео экологийн судалгаа, цацрагийн хяналтын асуудлуудыг тусгасан, хог хаягдлын менежмент, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хангуулах үүргийг хөрөнгө оруулагч талд хүлээлгэсэн. Уран агуулж байгаа давхаргын дээр орших ус давхаргыг уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа ашиглахыг хатуу хориглоод Байгаль орчин цацрагийн чиглэлээр 3 жил тутамд хөндлөнгийн аудит хийлгэх үүргийг хөрөнгө оруулагчид хүлээлгэсэн. Орон нутгийн хөгжилд 1 сая долларын тэр түрүүн санхүүжилтийг хийхээс гадна орон нутгийн хөгжил дээр одоо нөгөө дэд бүтцийн бүх бүтээн байгуулалтуудыг шууд уурхайд зогссоны дараа шилжүүлэх үүргийг хүлээлгэсэн. Мөн ажлын байртай холбогдуулаад 90-ээс доошгүй хувь нь Монгол хүн ажиллана гэдгийг хөрөнгө оруулагч талтай тохиролцсон. Нэг ёсондоо ажилд хүн авахдаа бол 90 хувь нь Монгол хүн ажиллана гэдгийг тохиролцсон. Ингээд ер нь Байгаль орчинтой холбоотой, уурхайн хаалт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг үйл ажиллагаа эхлэхээс өмнө боловсруулж 5 жил тутам шинэчлэн батлуулахыг тусгасан гээд Байгаль орчинтой холбоотой бүх стандарт шаардлагуудыг хангуулах ажлуудыг суулгасан. Үүн дээр Байгаль орчны ажлын хэсгээс нэмж хариулья.

Р.Сэддорж: Мандухай гишүүн тодруулж асууя. Мандухай гишүүн.

М.Мандхай: Миний асуултыг та нар өөрсдөө тодорхой сонсчих л доо. Би орон нутгийн хөгжилтэй холбоотой нийгэм, эдийн засгийн ямар үнэлгээ хийгдсэн бэ гэж энд асуусан.

Хоёрдугаарт энэ орон нутгийн чинь хөгжил та нар шилжин суурьших ажил дээр ямар төлөвлөгөө байгаа юм бэ? Ингээд шал өөр байгаль орчин гээд хамаг цагаа аваад явчхаж байгаа байхгүй юу. Нэг ийм тодорхойгүй энэ орон нутагт яах юм? Орон нутгийн бизнесийг яаж дэмжих юм? Говийн бүсийн хөгжилтэй энэ хэрхэн уялдах юм? Одоо энэ шилжилт хөдөлгөөн хийгдээд ирэхээр орон нутгийн өөрөө энэ уугуул иргэдэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх үүднээс энэ том төсөл чинь хэрэгжихийн тулд нийгэм эдийн засгийн үнэлгээ хийгдсэн үү, тэрэн дээр ямар ажлуудыг төлөвлөж байгаа юм гэдэг юм асуухлаар шал өөр Байгаль орчин яриад явчих юм.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Н.Учрал: Байгаль орчны үнэлгээ буюу нарийвчилсан үнэлгээ дотор нийгэм эдийн засгийн үнэлгээ нь дотор нь агуулагдаад явдаг. Дээрээс нь ТЭЗҮ дээр энэ бас байгаль орчны үнэлгээнүүд хамаардаг. Тэгэхээр нийгэм, эдийн засгийн үнэлгээ гэж байхгүй байхгүй юу. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ дотор энэ нийгэм, эдийн засгийн үнэлгээнүүд чинь

хамаардаг. Техник эдийн засгийн үнэлгээ дотор энэ Байгаль орчны үнэлгээнүүдийн чинь асуудлууд тусдаг. Орон нутгийн хөгжлийг дэмжих дээр ерөөсөө юу хэлж байна вэ гэхээр Үндэсний баялгийн сантай холбогдуулаад орон нутгийн хөгжлийн санд санхүүжилт орж байгаа. Мөн Дорноговь аймгийн тэр Улаанбадрах сум 4 жил тутам 1 тэрбум төгрөг авсаар ирсэн. Энэ мөнгө 2028 он хүртэл үргэлжилнэ. Уурхай ашиглаж эхэлсний дараа 1 сая доллар болно, уурхай зогссоны дараа нөхөн сэргээх 10 жилд 1.1 сая доллар төлөгдөнө. Энийг юунд зарцуулахыг аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга хамтын зөвлөлөөрөө шийдээд төлөвлөгөөгөө батална. Үүнийг сургууль, цэцэрлэг нийгмийн дэд бүтцэд ашиглах эрх нь нээгдэнэ.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу?

Төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа гишүүд. Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасалъя. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Би ажлын хэсгийнхний ажлыг бол үнэлж байгаа. Энэ дээр олон үзүүлэлтийг нарийн сайн тооцсон байна. Мэдээж бид нар хориод жилийн өмнө Оюу Толгойн гэрээ хийж байх үеийн нөхцөл байдал одоогийн нөхцөл байдал 2 өөр шүү дээ тиймээ. Одоо мэдээж Монгол Улс хөгжсөн байх ёстой, хүмүүс нь ажлаа хийж чаддаг байх ёстой. Тооцооллоо зөв сайн тайлбарлаж чаддаг байх ёстой. Би бол өнөөдөр та бүхний өгсөн материал дээр үндэслэж асуудал ярьж байгаа гэдгийг та бүхэн ойлгоорой. Ер нь бол АМНАТ-ийн асуудал дээр тооцооллын нэлээн нарийн ажлын хэсэгтэй уулзаж танилцъя гэж бодож байна аа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт.

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Жаргалан гишүүнийг протоколд дэмжсэнээр тэмдэглэе.

Санал хураалт явуулж дууслаа. Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна аа.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа. Эдийн засгийн байнгын хорооны энэ удаагийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна аа.

Гишүүдэд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд.

13.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

